



АГУУЛГА

Өмнөх үг	2
Нэг. Монгол Улсад иргэд хувиараа ашигт малтмал олборлох болсон нь	4
Хоёр. Хувиараа ашигт малтмал олборлогч (ХАМО)-дын үйл ажиллагааг хууль, тогтоомжоор зохицуулах шаардлага, бичил уурхайн хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх оролдлогууд	8
Гурав. Бичил уурхайн зохицуулалтын өнөөгийн хууль, эрх зүйн орчин, түүнийг ойлгох нь	33
Дөрөв. Бичил уурхайн талаар ТБУТ-ийн баримтлаж буй байр суурь	39
Тав. Бичил уурхайн цаашдын чиг хандлага	41
Зургаа. Гадаад орнуудын бичил уурхайн хөгжлийн түүх, өнөөгийн байдал	43
Долоо. Бичил уурхайн үйл ажиллагааг зохицуулж буй зарим улсын туршлага	45

ӨМНӨХ ҮГ

Монгол Улсын Засгийн газраас хүн амын ажилгүйдэл, ядуурал, байгалийн гамшиг зэрэг нийгэм, эдийн засгийн олон хүчин зүйлийн үлмаас хувиараа ашигт малтмал олборлох ажил эрхэлж байгаа иргэдийн үйл ажиллагааг зохион байгуулалтанд оруулах, үлмаар хөдөө орон нутагт хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны шаардлага хангасан ажлын байр бий болгох, эдийн засгийн үр ашигтай, зохих техник технологитой, байгаль орчны болон нийгмийн хариуцлагатай бичил уурхай болгохуйц эрх зүйн орчныг бүрдүүлэх бодлого баримталж байгаа билээ. Энэ бодлогын хүрээнд Эрдэс баялаг, эрчим хүчний яам (ЭБЭХЯ) Швейцарийн Хөгжлийн Агентлаг (ШХА)-тай хамтран Тогтвортой бичил уурхай төсөл (ТБУТ)-ийг хэрэгжүүлж байна.

Тогтвортой бичил уурхай төслийн хүрээнд тавьсан зорилтуудын нэг нь “Бичил уурхайд чиглэсэн төрийн таатай бодлогыг дэмжих, албан ёсны хариуцлагатай бичил уурхайг хөржүүлэхэд тохиромжтой хууль, эрх зүйн орчин бүрдүүлэхэд идэвхижүүлэгчийн үүрэг гүйцэтгэх, бичил уурхайн бодлого, зохицуулалтын ил тод, цэгцтэй орчин бий болгож, хэрэгжилтийг сайжруулах” явдал юм.

Иймд Монгол Улсын онцлогт тохирсон бичил уурхайн хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр ТБУТ өнгөрсөн 5 жилийнхээ ажлын хүрээнд Улсын Их Хурал, Засгийн газар, салбарын яамд, агентлаг, аймаг, орон нутгийн захиргаад, дотоодын болон олон улсын ТББ, бичил уурхай эрхлэгч иргэд, бусад оролцогч талуудтай нягт хамтран ажиллаж олон талт үйл ажиллагаа, арга хэмжээг санаачлан зохион байгуулж ажилласны үр дүнд тодорхой амжилтанд хүрсэн билээ. Төсөл хэрэгжиж эхлэхээс өмнө ч төр засгийн зүгээс энэ үйл ажиллагааг зохицуулах, хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх хэрэгцээ шаардлага байгааг ойлгож хэд хэдэн хуулийн төсөл санаачилж, салбарын сайдын бүрэн эрхийн хүрээнд журам баталж гарган хэрэгжүүлэх оролдлого хийсэн байдаг. Монгол Улсад бичил уурхайн эрх зүйн орчин бүрдүүлэх асуудал нь урт удаан хугацаа, хөрөнгө зарцуулсан,



олон байгууллага, хүний оюун ухаан, сэтгэл зүтгэл орсон ажил байлаа.

Энэхүү үйл хэрэгт холбогдох түүхэн тэмдэглэлийг бичиглэн үлдээх нь Монгол Улсын уул уурхайн салбарын түүхэнд ач холбогдолтой зүйл болно хэмээн үзэж бичил уурхайн хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэхэд чиглэгдсэн үйл явцын тоймыг эл товхимолд багтаахыг зорив. Товхимлын эх бэлтгэх явцад ТБУТ-ийн архивын материалыг өргөн ашиглаж ихээхэн хүч хөдөлмөр гаргаж ажилласан уул уурхайн инженер Н.Даваасамбуу, хуульч Т.Энхцэцэг, ТБУТ-ийн ажилтан нарт гүн талархал илэрхийлье.

ТБУТ-ийн Үндэсний захирал

П.Үржинлхүндэв

НЭГ. МОНГОЛ УЛСАД ИРГЭД ХУВИАРАА АШИГТ МАЛТМАЛ ОЛБОРЛОХ БОЛСОН НЬ

1.1. Нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлын нөлөө

Өнгөрсөн зууны 80-90-ээд оны заагаас манай оронд өрнөж эхэлсэн “шилжилтийн” гэх тодотголтой үйл явцын гол агуулга нь улс төр, нийгмийн харилцааг ардчилалд, төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийг чөлөөт зах зээлийн харилцаанд шилжүүлэх явдал байлаа. Энэхүү шилжилтийн эхний жилүүдэд хуучин ЗХУ болон Эдийн засгийн харилцан туслах Зөвлөлийн зээл, тусламж, зах зээлээс шууд хамааралтай байсан манай орны эдийн засаг уналтанд орж улмаар үйлдвэр, аж ахуйн олон газар хаалгаа барьж, хэдэн мянган хүн ажилгүй болсон билээ. Мөн түүнчлэн эдийн засгийг зах зээлийн харилцаанд шилжүүлэхтэй холбогдуулан төрийн өмчийн хувьчлал, бараа бүтээгдэхүүний үнийн чөлөөлөлт, мөнгөний масштабын өөрчлөлт, банкны системийн шинэ тогтолцоо бий болгох зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлсэн нь эерэг болон сөрөг үр дагаварын аль алиныг авчирсан юм. Эдгээр арга хэмжээг авч хэрэгжүүлэхдээ асуудлыг өргөн хүрээтэй харж, гарах үр дагаварыг төдийлөн тооцож чадаагүйгээс мөнгөний үнэ ханш унаж, хөрөнгө цөөн тооны хүмүүсийн гарт төвлөрч хүмүүсийн дунд баян, ядуу, өмчтэй, өмчгүй, ажилтай, ажилгүй хүн гэсэн нийгмийн том ялгаа гарч ажилгүй, ядуу иргэдийн тоо үлэмж нэмэгдсэн байна. Үүний зэрэгцээ манай орны нийт нутгийг хамарсан удаа дараагийн байгалийн гамшиг, ган зуданд нэрвэгдэж хотоо харлуулан малгүй болсон, амь зуулгаасаа салсан иргэдийн тоо жил ирэх тусам өсөж байгаагийн хэрээр ажилгүйчүүдийн эгнээ улам өргөжсөөр байгаа билээ. Ийнхүү нийгэм, эдийн засгийн олон учир шалтгааны улмаас ажилгүй болсон ядуу иргэд амьжиргаагаа залгуулах гэж хувиараа ашигт малтмал олборлох ажиллагаанд олноор татагдан орох болсон юм.

1.2. Уул уурхайн салбар, алт хөтөлбөрийн нөлөө

Шилжилтийн эхэн үеийн нийгэм, эдийн засгийн байдал уул уурхайн салбарт ч хүндээр тусаж, улс нийгмийн амьдралд



сөргөөр нөлөөлж байв. Нүүрсний томоохон үйлдвэрүүдийн сэлбэг, материал, түлш шатахууны олдоц хомсдон, үнэ нь өсөж, өртөг зардал нэмэгдэсний дээр цахилгаан, дулаан хэрэглэгчид дулаан, цахилгааны станцуудад, станцууд нь уурхайнуудад өртэй гэх мэтээр өрийн гинжин хэлхээ үүссэн, Эрдэнэт, Бор-Өндөрийн уул уурхайн баяжуулах үйлдвэр зэрэг томоохон хамтын аж ахуйнууд бүрэн хүчин чадлаараа ажиллаж чадахгүй үйлдвэрлэлээ дөнгөн данган явуулж, үндэсний хүнд, хөнгөн бүх үйлдвэр зогсолтын байдалд орсноос улсын төсвийн орлого хомсдож, төсөв бүрдүүлэхэд хүндрэл учирсан.

Тийм учраас улс орны эдийн засгийг тэнхрүүлэхэд түшиг тулгуур болохуйц дорвитой арга замыг олж хэрэгжүүлэх нь юу юунаас чухал байсантай холбоотойгоор төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн үед хайгуул хийж, нөөцийг нь тогтоосон алтны нэлээд тооны ордоос алт олборлож, эдийн засагт аврал, дэмжлэг үзүүлэх зорилго бүхий “Алт” хөтөлбөрийг Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачлагаар боловсруулан хэрэгжүүлсэн. 1990-ээд оны эхээр Төв аймгийн Заамар, Сэлэнгэ аймгийн Баянгол зэрэг сумдын нутагт “Алт” хөтөлбөрийн эхний үйлдвэрүүд байгуулагдаж эхэлсэн.

1994 оноос “Алт” хөтөлбөрийн хэрэгжилт эрчимжсэн бөгөөд Туул, Шарын гол, Хараа, Ерөө, Бороо, Байдраг голын сав, Хангай, Хэнтий, Заамар, Дөвөнтийн нурууны салбар уулсын ам, хөндийг дагасан олон тооны алтны уурхайнууд байгуулагдан ажиллаж эхэлсэн. Ийнхүү *алтны уурхайнууд олширсон нь тодорхой тооны ажлын байр бий болгохын зэрэгцээ ажилгүй, ядуу иргэд тэдгээр уурхайн ашиглалтын болон технологийн хаягдлаас алт олборлох нөхцлийг бүрдүүлжээ.* Иргэд хувиараа алт олборлоход ямар нэг эрх зүйн зохицуулалт байхгүйгээс хариуцлагын тогтолцоо мэдээж байсангүй. Олсон алт нь тэр даруй мөнгө болон хувирдаг байсан нь олон ажилгүйчүүдийн сонирхлыг татсан төдийгүй, цөөн бус ашиг хонжоо хайгчдыг ч татах болсон байна. Мөн түүнчлэн 1990 онд Налайхын их уурхай хаагдсанаас 3000-5000 уурхайчин ажилгүй болж, хувиараа нүүрс олборлон борлуулж амьдрах болсон зэргээс үүдэн хувиараа ашигт малтмал олборлогчид олон мянгаараа бий болох нөхцлүүд бүрджээ.

1.3 Иргэд хувиараа ашигт малтмал олборлож эхэлсэн нь

Монгол Улсад 1990-ээд оны эхэн үеэс иргэд хувиараа ашигт малтмал олборлох болсон шалтгаан нь нийгэм, улс төр, эдийн засаг, уул уурхайн салбарын тухайн үеийн нөхцөл байдал нь өөрөө байсан гэдгийг дээр дурьсан билээ.

Анх 1997 оноос эхлэн Сэлэнгэ аймгийн Баянгол сумын нутагт Бороогийн алтны бүлэг ордоос иргэд хувиараа алт олборлох болсноор хувиараа ашигт малтмал олборлох үйл ажиллагаа эхэлсэн гэж албан ёсоор үздэг. Энэ сумын иргэд алтны агуулга бүхий хүдэр олборлож, түүнийгээ төмөр уур, нүдүүр хэрэглэн буталж, нунтаглаад түүнээсээ мөнгөн усны тусламжтайгаар алт ялган авч эхэлсэн байна.

Тийнхүү энэ нутагт хувиараа алт олборлож эхэлсэн нь тохиолдлын бус гэж үзэж болохоор байна. Учир нь 1940-1954 онд Монгол улсын Дотоод яамны шийдвэрээр Бороо голын орчимд алт олборлож байсан түүх байдаг бөгөөд алт ялган авахдаа мөнгөн ус хэрэглэж байсан гэдэг. Тэр ч бүү хэл мөнгөн ус агуулж байсан сав нь цоорсноос их хэмжээний мөнгөн ус Бороо голын усанд асгарсныг хувиараа алт олборлогчид одоо хэр нь тунгааж авсаар байгаа билээ. Үүнээс дүгнэн үзвэл алт олборлох хуучин арга, технологи нь энэ нутгийн хаа нэгэнтээ хадгалагдан нуугдаж байгаад хувиараа алт олборлогчдоор дамжин ил гарч дэлгэрсэн байна.

1998, 1999 оноос Төв аймгийн Заамар, Сэлэнгэ аймгийн Ерөө зэрэг сумын нутагт ажиллаж байсан алтны уурхайнуудын ашигласан талбай, технологийн хаягдлаас иргэд хувиараа алт олборлох болсон. Тэр үед хувиараа алт олборлогчдыг Төв аймгийн Заамар орчимд “нинжа”, Сэлэнгэ аймгийн Бугант орчимд “аляскийнхан” хэмээн нэрлэж байв.

1999-2002 онд улс орныг бүхэлд нь хамарсан ган, зуд, байгалийн гамшиг тохиолдож, олон мянган малчин өрх амьжиргааныхаа эх үүсвэр болсон малаасаа салж, газар тариалангийн үйлдвэрлэл зогсолтын байдалд орсны улмаас ажилгүй, ядуу иргэдийн тоо огцом өсөж, тэд арга буюу ашигт малтмал олборлон амьдарлаа залгуулах болсон. Тэгэхдээ зөвхөн алт ч бус, тухайн орон нутагт олборлож, борлуулж болохоор ямар л эрдэс баялаг байна түүн рүү дайрцагасан байна.



2002 оноос хойш хувиараа ашигт малтмал олборлогчдын тоо эрс өсөж, малгүй, ажилгүй жинхэнэ ядуу иргэдээс гадна цөөн малтай малчид, олз хайгчид, наймаачид, оюутан сурлагчид, тэр ч бүү хэл орон нутгийн төсвийн байгууллагын амралтаа авсан ажилтнууд хүртэл энэ тоонд багтах болов. Ингэсээр 2007 он гэхэд Монгол улсын 19 аймгийн 80 гаруй сумын нутаг дэвсгэрийн 100 гаруй цэгээс 10 гаруй нэр төрлийн ашигт малтмал олборлодог 100 мянгаар тоологдох хувиараа ашигт малтмал олборлогчтой болсон байлаа.

Тэдгээрээс Төв аймгийн Заамар, Сэлэнгэ аймгийн Баянгол, Мандал, Дархан-Уул аймгийн Шарынгол, Өвөрхангай аймгийн Уянга, Баянхонгор аймгийн Баян-Овоо, Бөмбөгөр, Жаргалант, Говь-Алтай аймгийн Чандмань, Увс аймгийн Түргэн, Өмнөговь, Дорноговь аймгийн Айраг, Хатанбулаг, Өмнөговь аймгийн Мандал-Овоо, Цогт-Овоо, Дундговь аймгийн Өлзийт, Хөвсгөл аймгийн Рэнчинлхүмбэ сумд, Улаанбаатар хотын Налайх дүүрэгт хувиараа ашигт малтмал олборлогчдын олонхи нь төвлөрч байна.

ХОЁР. ХУВИАРАА АШИГТ МАЛТМАЛ ОЛБОРЛОГЧ (ХАМО)-ДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХУУЛЬ, ТОГТООМЖООР ЗОХИЦУУЛАХ ШААРДЛАГА, БИЧИЛ УУРХАЙН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ БҮРДҮҮЛЭХ ОРОЛДЛОГУУД

2.1 Хууль, тогтоомжоор зохицуулах шаардлага

ХАМО-чид бий болсноор нийгэмд сайн, муу үр дагаврын аль алиныг дагуулсан. Сайнаас нь дурьдвал эдгээр хүмүүс өөрсдийн хүч хөдөлмөрөөр амьдралаа залгуулж, ам бүлээ тэжээж байгаагаас гадна дагалдах үйлчилгээний албан бус ажлын байруудыг бий болгож, зах зээл, зам харилцааны сүлжээг үүсгэж, хөдөөд мөнгөний эргэлт бий болгож, хөдөөгийн ард иргэдийн худалдан авах чадвар нэмэгдэж, малчдын орлого өсөж, олон мянган оюутан сурагчид сургалтын төлбөрөө олж, зарим иргэд мөнгөн хуримтлалтай болж, олон мянган айл өрхийн амьдрал эндээс эх үүсвэртэй болсон. Ажил мэргэжлийн чиг баримжаа, хөдөлмөрийн шинэ хуваарь ч үүссэн байна.

Саараас нь дурьдвал байгаль орчин, ус бэлчээр сүйтгэдэг, татвар төлдөггүй, нутгийн иргэд малчдын болон үүл уурхайн албан компаниудын эрх ашигт сөрөг нөлөө үзүүлдэг, гэмт хэрэг, хэв журмын зөрчил нэмэгдсэн, хүний эрх зөрчигддөг, химийн хортой, аюултай бодисын хэрэглээ өсөх болсон, уурхайн осол эндэгдлийн тоо өсөж, хүний амь эрсдэх, архидах, биеэ үнэлэх үзэгдэл нэмэгдсэн, мэргэжлээс шалтгаалах болон нийгмийн халдварт өвчний өвчлөл ихэссэн, хүүхдийн хөдөлмөрийг ашигладаг, орон нутгийн засаг захиргааны зардал, ажлын ачааллыг нэмэгдүүлж, төсөвт хүндрэл учруулдаг гэх мэт.

Хувиараа ашигт малтмал олборлох явдал нэгэнт төр, нийгэм, байгаль, цаг уурын тухайн үеийн нөхцөл байдлаас шууд шалтгаалан бий болж, хамрагдах хүмүүсийн тоо, орон зай, нутаг дэвсгэрийн тархалт, олборлож буй ашигт малтмалын төрөл зүйлийн хувьд нэлээд өсөж, улс орныг бүхэлд нь хамарсан шинжтэй болсны дээр цаашид өөрийнхөө аясаар юуу төр, засгаас хориглосноор зогсож, устаж арилахгүй нь тодорхой болсон учир ХАМО-дын үйл ажиллагааны нийгэмд үзүүлж байгаа

сайн, муу нөлөөллийн сайныг нь дэмжиж зохицуулах, зохион байгуулалтанд оруулах, сөрөг муу нөлөөллийг бууруулах, хязгаарлах улмаар арилгах бодлогыг төр, засгаас боловсруулж, хэрэгжүүлэх бодит шаардлага зүй ёсоор гарсан.

Өөрөөр хэлбэл ХАМО-дыг зохицуулалттайгаар нийгмийн харилцаанд оролцох хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх хэрэгтэй болсон. Нийгмийн харилцаанд оролцох гол эрх буюу зөвшөөрөл нь уг харилцааг зохицуулах хуулийг төрийн эрх бүхий байгууллагаас батлан гаргах явдал байлаа.

Хууль батлагдсанаар бусад эрх зүйн харилцаанд оролцох үүд хаалга нь нээгдэж, ХАМО-дын үйл ажиллагааны онцлог, өвөрмөц байдлыг зохицуулахад хэрэгтэй эрх зүйн бусад актууд боловсруулагдаж, зохих эрх бүхий байгууллагаар батлагдан, хэрэгжиж, үйлчилж эхлэнэ.

ХАМО-дын үйл ажиллагааны хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэхэд чиглэгдсэн дотоод, гадаад нөлөөлөл ч олон байсан. Тухайлбал, ядуурлыг бууруулах, хөдөө дэх хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхийн тулд ХАМО-дын үйл ажиллагааг зохион байгуулалтанд оруулан дэмжих шаардлага гарч байхад тэдний үйл ажиллагаанаас улбаалаад байгаль орчныг сүйтгэх сөрөг үйлдлийг бууруулах зайлшгүй хэрэгцээ гарч ирсэн. Монгол улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцын үзэл баримтлалууд, глобал компакт буюу даяаршлын тунхаглал, байгаль орчныг хамгаалах олон улсын бичиг, баримтууд, хүний эрхийн гэрээ, конвенцууд зэрэг нь гадаад нөлөөлөл болж байв.

2.2 Бичил уурхайн хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх оролдлогууд

Иргэд хувиараа ашигт малтмал олборлож байгаа үйл ажиллагааг хууль, эрх зүйн үүднээс үнэлж, дүгнэсэн олон янзын үзэл баримтлал олон нийтийн дунд байлаа. Үүнд:

1. 2010 оны 07 сарын 01-ээс өмнө мөрдөгдөж байсан Ашигт малтмалын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 заалтад “Тусгай зөвшөөрөлгүйгээр ашигт малтмал эрэх, хайх, ашиглахыг хориглоно” гэж заасан байдаг тул иргэд тусгай зөвшөөрөлгүйгээр ашигт малтмал олборлож байгаа нь хууль бус, хууль зөрчсөн үйл ажиллагаа гэж үздэг олон хүмүүс байсан.

2. Албан бус хөдөлмөр эрхлэлтийн нэг хэлбэр мөн гэж үздэг байгууллага, хувь хүмүүс ч цөөнгүй байлаа.

3. Албан бус хөдөлмөр эрхлэлт гэсэн ойлголтын тодорхойлолтонд *“Албан бус хөдөлмөр эрхлэлт гэдэгт албан ёсны бүртгэл, мэдээлэл, нийгмийн хамгаалалд бүрэн хамрагдаагүй, хөдөө аж ахуйн бус, аж ахуй эрхлэх, аливаа нэгэн зохион байгуулалтын хэлбэрт ороогүй, хуулиар хориглоогүй ажил, үйлчилгээг хувь хүн, өрх, хамтлаг эрхлэхийг хамруулна”* гэж заасан тул мөн албан бус хөдөлмөр эрхлэлт биш гэж үздэг хүмүүс ч байсан.

4. Нийгмийн амьдарлын шаардлагаар бий болсон бөгөөд хуульчлагдаж амжаагүй, хөдөлмөрийн шинэ салбар, төрөл гэж хөдөө, орон нутгийн олонхи иргэд үзэж байв.

Тиймээс энэ олон үзэл баримтлалыг нэг мөр болгосон хуулийн зохицуулалт хэрэгтэй болох нь 2002 оны үеэс тодорхой болсон учир төрийн ба төрийн бус, олон улсын зарим байгууллагууд ХАМО-дын ажил амьдарлын талаар судалгаа хийх, семинар, уулзалт, зөвлөлгөөн зохион байгуулах зэргээр үйл ажиллагаагаа нэгтгэн ажиллаж, шийдлийн зөв оновчтой хувилбарыг эрэлхийлж эхэлсэн.

ХАМО-дын үйл ажиллагааны хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэхийн төлөө ажлыг санаачлан зохион байгуулж, идэвхи чармайлт гарган ажиллаж байсан байгууллага, хүмүүсээс заримыг нь нэрлэвэл: Тухайн үеийн Үйлдвэр, худалдааны яам (ҮХЯ), Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газар (АМГТХЭГ), Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам (НХХЯ), Байгаль орчин, аялал жуулчлалын яам (БОАЖЯ), Улсын мэргэжлийн хяналтын газар (УМХГ), Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо (МАОЭНХ), Монголын үйлдвэрчний эвлэлүүдийн холбоо (МҮЭХ), Монголын уул уурхайн үндэсний ассоциаци (МУУҮА), Олон улсын хөдөлмөрийн байгууллаг (ОУХБ)-ын Монгол дахь Үндэсний хөтөлбөр, Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА), Төв аймгийн Засаг даргын тамгын газар, Борнуур, Заамар сумын засаг захиргаа зэрэг байгууллагууд, ҮХЯ-ны мэргэжилтэн О.Цэндсүрэн, АМГТХЭГ-ын Уул уурхайн газрын дарга Б.Магванжав, хэлтсийн дарга С.Баттулга, НХХЯ-ны мэргэжилтэн Ч.Эрдэнэчимэг, МАОЭНХ-ны Гүйцэтгэх захирал Х.Ганбаатар, төслийн зохицуулагч Г.Оюундарь, МУУҮА-ийн Гүйцэтгэх захирал Н.Алгаа, Ерөнхий менежер О.Зоригт, ОУХБ-ын Үндэсний хөтөлбөрийн менежер Н.Монголмаа, геохимич

Б.Түмэнбаяр, УИХ-ын гишүүн асан Л.Цэрэнжав, Л.Даваацэдэв нарын зэрэг хүмүүс идэвхи, санаачлага гарган ажиллаж байв.

Эдгээр байгууллага, хүмүүсийн санаачлагаар дараах ажлууд зохион байгуулагдаж байжээ. Үүнд:

- 2002 онд УИХ, Засгийн газрын гишүүд, орон нутгийн засаг захиргааны ажилтнууд, төрийн бус байгууллага, хувиараа ашигт малтмал олборлогчдын төлөөлөгчид, уул уурхайн компаниудын ажилтнууд оролцсон “Гар аргаар ашигт малтмал олборлолт” сэдвээр Улаанбаатар хотноо зөвлөлгөөн хийж, ХАМО-дын үйл ажиллагааг зохицуулах хууль боловсруулж батлуулах, ХАМО-дыг бүртгэлжүүлэх, олборлосон ашигт малтмалыг худалдан авах журам тогтоох зэрэг асуудлаар зөвлөмж гаргасан.
- “Ашигт малтмал гар аргаар олборлох тухай” хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийг томилон 2002-2003 онд Баянхонгор, Өвөрхангай, Өмнөговь, Сэлэнгэ, Төв, Дорноговь, Хэнтий аймгуудад томилолтоор ажиллаж, ХАМО-дын үйл ажиллагаатай газар дээр нь танилцаж, тэдний төлөөлөгчид, орон нутгийн удирдлага, албан байгууллага, ард иргэд, лицензи эзэмшигчид, уул уурхайн компанийн төлөөлөлтэй уулзаж, холбогдох судалгаа хийсэн.
- 2003 онд “Ашигт малтмал гар аргаар олборлох тухай” хуулийн төслийг тухайн үед УИХ-ын гишүүн асан Л.Цэрэнжав санаачилан боловсруулж, УИХ-аар хэлэлцүүлэхээр өргөн барьсан.
- 2003 онд ЖАЙКА-ийн шугамаар Төв аймгийн Борнуур, Сүмбэр, Сэлэнгэ аймгийн Баянгол сум, Бороо, Хараа голуудын сав нутгийг хамарсан мөнгөн усны бохирдолтын судалгаа хийж, тайлан гаргасан.
- 2004 оны 12 дугаар сард МАОЭНХ МУУҮА-тай хамтран “Ашигт малтмал гар аргаар олборлолт ба ажил олгогч эздийн байгууллагын үүрэг, оролцоо” сэдэвт семинар зохион байгуулж бодлого боловсруулагч, хэрэгжүүлэгч болон бусад оролцогч талуудыг оролцуулан ХАМО-дын үйл ажиллагааны хууль, эрх зүйн орчинг бүрдүүлэх тухай зөвлөмж, уриалга гаргажээ.
- 2004-2005 онд Олон улсын хөдөлмөрийн байгууллагын техникийн болон мэргэжлийн туслалцаатайгаар “Монгол дахь уурхайн албан бус дэд салбарын эрх зүйн

зохицуулалтыг болвсронгүй болгох нь” гэсэн сэдвээр суурь судалгаа явуулжээ.

- МАОЭНХ-оос “Гар аргаар алт олборлогчдын нөхцлийг сайжруулах, албан бус уурхай дахь хүүхдийн хөдөлмөрийг устгах төсөл”-ийг боловсруулан Төв аймгийн Борнуур, Заамар сумуудад 2004-2006 онд хэрэгжүүлсэн. Энэ ажлын хүрээнд ХАМО-чид, тэдний хүүхдүүдийн амьдрал ахуйн талаар судалгаа хийхээс гадна сургуулиас завсардсан хүүхдүүдийг сургалтанд хамруулах, 16-18 насны хүүхдүүдэд мэргэжил эзэмшүүлэх ажлыг зохион байгуулахын зэрэгцээ Борнуур, Заамар сумын ХАМО-дын дэргэд сургалт, сурталчилгааны гэрүүд ажиллуулж, хууль, эрх зүйн уулзалт, сурталчилгаа зохион байгуулж байв.

АМГТХЭГ-аас Швейцарийн хөгжил, хамтын ажиллагааны агентлаг (ШХХАА, хуучин нэрээр)-тай хамтран “Бичил уурхайг дэмжих төсөл” боловсруулж, 2005 оны 7 дугаар сарын 1-ээс эхлэн хэрэгжүүлж, үйл ажиллагааг нь ШХХАА-аас санхүүжүүлж эхэлсэн нь бичил уурхайн асуудлыг салбар, мэргэжлийн зүгээс төвлөрүүлэн авч үзэх, хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх талаар дээр дурьдсан байгууллагууд болон бусад оролцогч, сонирхогч талуудын хамтын нөхцөлд тулгуурлан, тасралтгүйгээр эрч хүчтэй ажиллах таатай нөхцөл, чухал хүчин зүйл болсон юм.

Бичил уурхайг дэмжих (БУД) төсөл (2005-2007 онд буюу төслийн туршилтын хугацаанд ийнхүү нэрлэж байсан, 2007 оноос хойш Тогтвортой бичил уурхай гэж нэрлэх болсон) нь үйл ажиллагаагаа эхэлсэн цагаасаа эхлэн бичил уурхайн хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх, ХАМО-дын үйл ажиллагааг бичил уурхай болгон хөгжүүлэх баттай үндэс суурийг тавихын төлөө идэвхи чармайлт гарган ажиллаж байна. Тогтвортой бичил уурхай төсөл (ТБУТ) хэрэгжиж эхэлснээс хойш уг төслийн үндэсний зохицуулагчаар ажилласан Д.Одончимэг (2005), Б.Хулдорж (2006-2008), Ө.Батсайхан (2008-2009), П.Үржинлхүндэв нар (2009 оноос хойш) болон төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилтнууд ХАМО-дын хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэхийн төлөө мэдлэг чадвар, бие сэтгэлээ зориулж, хувь нэмрээ оруулсан байна.

ТБУТ-ийн үйл ажиллагааны хөтөлбөрт 2002 оны үеэс эхлэн ХАМО-дын үйл ажиллагааг зохион байгуулалтанд оруулах, хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэхийн төлөө ажиллаж байсан төрийн ба төрийн бус, олон улсын байгууллагуудын ажлын

зарим үзэл баримтлал тодорхой хэмжээнд тусгагдан хэрэгжсэн болно.

ХАМО-дын үйл ажиллагааг зохицуулах гэсэн анхны оролдлого буюу эл зорилгоор гарсан эрх зүйн анхны баримт бичиг нь Үйлдвэр худалдааны сайдын 2002 оны 05 сарын 24-ний өдрийн 53 дугаар тушаалаар батлагдсан “Ашигт малтмалыг үйлдвэрлэлийн бус аргаар олборлох түр журам” байлаа.

2002 онд буюу “Ашигт малтмалыг үйлдвэрлэлийн бус аргаар олборлох түр журам” батлагдах үед Заамар, Бугант, Баянгол, Уянга зэрэг газруудад хувиараа алт олборлогчдын төвлөрөл үүсэж, хувиараа жонш олборлох явдал Дорноговь аймагт газар авч, Налайхад хувиараа нүүрс олборлох ажил ид өрнөж, байгаль орчны болон нийгмийн сөрөг үзэгдлүүд бий болсон нь төр, засгаас анхаарахгүй байхын аргагүй байдалд хүрсэн байв.

Дээрх журамд “*Ашигт малтмалыг хууль бусаар олборлож байгаа ажиллагааг зохион байгуулалтанд оруулж, ажлын байр бий болгосноор орон нутгийн төсвийн орлогыг нэмэгдүүлэх, ашиглалтын явцад байгаль орчинд үзүүлж байгаа сөрөг нөлөөллийг багасгах, хөдөлмөр хамгаалал, аюулгүйн ажиллагаанд хяналт тавихад энэ журмын зорилго оршино*”¹ гэж тодорхойлж байснаас үзэхэд ХАМО-дыг зохион байгуулалтанд оруулж, үйл ажиллагааг нь дэмжих санаа тухайн үеийн Үйлдвэр худалдааны яам (ҮХЯ)-нд байсан болох нь харагддаг.

Энэ журмын гол үзэл санаа нь сум /дүүрэг/-ын Засаг дарга Ашигт малтмалын тухай хуулийн дагуу ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй харилцан тохиролцож, гэрээ байгуулснаар түүний эзэмшил талбайн аль нэг хэсэгт нь ХАМО-дыг ажиллуулахад оршиж байсан.

Гэвч тэр журам дараах хэдэн зүйлийн шалтгааны улмаас хэрэгжээгүй юм. Үүнд:

1. Уг журмыг боловсруулахдаа тодорхой судалгаагүй хандаж, өнгөцхөн харж, хялбарчилсан байдлаар зохицуулахыг оролдсон;
2. Үйл явцын цаашдын өрнөлийг харж, ХАМО-дын талаар баримтлах үзэл санаагаа бодлого болтол боловсруулж чадаагүй;

¹ “Ашигт малтмалыг үйлдвэрлэлийн бус аргаар олборлох түр журам”-ын 1.1 дүгээр заалт

3. “Үйлдвэрлэлийн бус арга”-аар гэсэн нь бодит байдал нийцээгүй;
4. “*Ашигт малтмалыг үйлдвэрлэлийн бус аргаар олборлох иргэд, хуулийн этгээдийг сум /дүүрэг/-ын татварын алба “Аж ахуйн нэгжийн тухай” хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу бүртгэлжүүлнэ*”² гэж заахдаа “хуулийн этгээд” гэсэн нь зөрчилтэй байсан. Учир нь Иргэний хуулийн 25.1-д зааснаар “хуулийн этгээд” гэдгийг “*Өмчлөлдөө буюу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхтэй тусгайлсан хөрөнгөтэй, өөрийн нэрээр эрх олж, үүрэг хүлээдэг, үйл ажиллагаанаасаа бий болох үр дагаварыг эд хөрөнгөөрөө хариуцдаг, нэхэмжлэгч, хариуцагч байж чадах, тодорхой зорилго бүхий, тогтвортой үйл ажиллагаа эрхэлдэг зохион байгуулалтын нэгдлийг хуулийн этгээд гэнэ.*” гэж тодорхойлсон байдаг тул уг журмын зорилго, агуулгатай нь зөрчилдөж байсан.
5. “Ашигт малтмалыг үйлдвэрлэлийн бус аргаар олборлох түр журам”-ыг хэрэгжүүлэх зорилгоор АМГТХЭГ-аас ХАМО нар ихээр төвлөрсөн Төв аймгийн Заамар, Баянхонгор аймгуудад тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлсэн боловч журам нь өөрөө нэлээд зөрчилтэй боловсруулагдсан тул дорвитой хэрэгжээгүй байна.

Дээрх журам нь хэдийгээр хэрэгжээгүй ч гэсэн ХАМО-дын үйл ажиллагааг зохицуулах гэсэн анхны оролдлого, эрх зүйн албан ёсны, анхны акт байсан гэдгээрээ ач холбогдолтой юм.

Дараагийн оролдлого нь УИХ-ын гишүүн асан Л.Цэрэнжавын боловсруулж, 2003 оны 06 дугаар сарын 06-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Ашигт малтмал гар аргаар олборлох тухай” хуулийн төсөл юм.

Тэрхүү хуулийн төслийн гол үзэл баримтлал нь ХАМО-ч иргэд нэгдэж, Иргэний хуулийн 481.1-д заасны дагуу “Бүртгэгдээгүй нөхөрлөл” байгуулан, тухайн сум /дүүрэг/-ын Засаг даргад хүсэлт гаргаснаар бүртгүүлж, Засаг даргаас нөхөрлөлд олгосон нэгж талбайд ашигт малтмал олборлох тухай гэрээ байгуулан ажиллахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршиж байсан.

² “Ашигт малтмалыг үйлдвэрлэлийн бус аргаар олборлох түр журам”-ын 2.1 дүгээр заалт

Нэгж талбайг ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайд түүнийг эзэмшигчийн зөвшөөрсөн хэсэгт, эсвэл уурхайн эдэлбэрээс Ашигт малтмалын хуулийн дагуу буцааж хүлээлгэн өгсөн талбайд олгохоор заасан.

Уг төсөлд “ашигт малтмал гар аргаар олборлох”, “ашигт малтмал гар аргаар олборлох нөхөрлөл”, “бага хүчин чадлын тоног төхөөрөмж”, “ашигт малтмал гар аргаар олборлох нэгж талбай” гэсэн ойлголтуудыг тодорхойлж, дээрх нөхөрлөлийн ажиллах зарчмыг тогтоох талаар нэлээд дэлгэрэнгүй авч үзсэнээрээ онцлог байсны дээр ХАМО-дын үйл ажиллагааны хууль, эрх зүйн зохицуулалтын үүд хаалгыг нээх хуулийг батлуулах гэсэн анхны оролдлого байснаараа зохих ач холбогдолтой байв.

Эл хуулийн төсөлд:

4.1.3 “бага хүчин чадлын тоног төхөөрөмж” гэж 500 шоо см-ээс ихгүй дотоод шаталтын хөдөлгүүртэй механизмыг хэлнэ,

10.2 Нэгж талбайн хэмжээг нөхөрлөлийн нэг гишүүнд 0.005 хүртэл га газар оногдохоор тооцох бөгөөд нэг нөхөрлөлийн ашиглах нэгж талбайн хэмжээ 0.5 га-аас илүүгүй байна. гэж заасан нь амьдралд дэндүү нийцгүй байсан. Тухайлбал: 500 шоо см-ээс ихгүй дотоод шаталтын хөдөлгүүр гэж зааснаараа ХАМО-дын өсөж дэвжих бололцоог хаасан бол 0.005 га-аас илүүгүй талбай гэдэг нь 50 хавтгай дөрвөлжин метр буюу хааш хаашаа 7.07 метр газар юм. Энэ нь бараг хэмжиж өгчихөөд эргээд харахад ухаад дуусчихсан байхаар талбай билээ.

4.1.2 “ашигт малтмал гар аргаар олборлох нөхөрлөл” /цаашид “нөхөрлөл” гэх/ гэж иргэд ашигт малтмал гар аргаар олборлох зорилгоор иргэний хуулийн 481.1-д заасны дагуу зохион байгуулагдаж, ... хэмээн заасан байна.

Мөн нөхөрлөлийн талаар дэндүү нарийвчлан авч үзсэн нь хуулийн төслийг нөхөрлөлийн дүрэм шиг болгосон зэрэг дутагдалтай талууд байсан юм.

УИХ-аар уг хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийсэн боловч хоёр дахь хэлэлцүүлэг болохоос өмнө тухайн УИХ-ын бүрэн эрхийн хугацаа дуусгавар болж, дараагийн парламентад шилжсэн. УИХ-ын 2004 оны сонгуулиар хууль санаачлагч Л.Цэрэнжав УИХ-ын гишүүнээр дахин сонгогдоогүй тул уг хуулийн төсөл дахин хэлэлцэгдэх боломжгүй болж, УИХ-ын 2005 оны 12

сарын 08-ны өдрийн 76 дугаар тогтоолоор Ашигт малтмал гар аргаар олборлох тухай, Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ашигт малтмал гар аргаар олборлох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль болон Ашигт малтмал гар аргаар олборлох тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг буцааж, эдгээр төслүүдийг дахин боловсруулж, өргөн мэдүүлэхийг Засгийн газарт даалгажээ. УИХ-ын 2005 оны 76 дугаар тогтоолын дагуу “Ашигт малтмалыг гар үйлдвэрлэлийн аргаар олборлох тухай” хуулийн төслийг Засгийн газраас 2006 оны 09 сард Улсын Их Хуралд өргөн мэдүүлжээ..

Уг хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэгт зөвлөхөөр ажиллаж байсан Монгол улсын анхны Ерөнхийлөгч, уул уурхайн инженер, доктор, профессор П.Очирбат ХАМО-дын үйл ажиллагааг уурхайн ашиглалтын ба боловсруулах технологийн хаягдал болон үүсмэл орд, үйлдвэрлэлийн аргаар ашиглахад эдийн засгийн үр ашиггүй орд, илэрц рүү чиглүүлэх талаар санал, зөвлөмжүүдийг өгч байжээ.

Л.Цэрэнжавын боловсруулсан төсөл “Ашигт малтмал гар аргаар олборлох тухай” төслийн нэрний “гар аргаар” гэдэг үгийг нэлээд шүүмжлэх, шоглох хандлага байсан учраас “Гар үйлдвэрлэлийн аргаар ашигт малтмал олборлох тухай” гэж засварлан найруулж хэрэглэсэн. Энэ нэрээрээ хагас жил орчим хугацаанд олон нийтийн уулзалт ярилцлага, семинар зөвлөлгөөн, төрийн ба төрийн бус байгууллагуудад танилцуулагдаж байх явцад ХАМО-дыг хүрз, жоотуу барьж, байгаль орчныг сүйтгэсэн, эмх замбараагүй хэвээр нь байлгахаар хуульчлах гэж байгаа мэтээр ойлгох, эсэргүүцэх явдал багагүй гарч байсны улмаас уг нэрийг сольж “**Бичил уурхайн тухай**” хуулийн төсөл гэж нэрлэсний зэрэгцээ хуулийн төслийг олон нийтээр хэлэлцүүлэхэд гарч байсан санал, зөвлөмжүүдийг тусгах, шинэ нэрний агуулгад нийцүүлэх шаардлага шинээр гарсан тул Бичил уурхайг дэмжих төслийн ажилтнууд дахин засварлаж, боловсруулсан байна.

“Бичил уурхайн хууль”-ийн төслийг дагаад “Газрын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай”, “Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай”, “Бичил уурхайн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай”, “Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт оруулах тухай”

хуулийн төслүүд, “Бичил уурхайн тухай” хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл боловсруулсан байна.

“Бичил уурхайн тухай” хуулийн тэрхүү төслийг тухайн үед УИХ-ын гишүүн асан С.Ламбаа, Р.Бадамдамдин, Д.Бат-Эрдэнэ, Г.Батхүү, Ц.Баярсайхан, С.Баярцогт, Г.Занданшатар, Д.Лундаажанцан, Ц.Сүхбаатар, З.Энхболд, Р.Нямсүрэн нарын 11 гишүүн 2006 оны 7 дугаар сарын 06-нд УИХ-д өргөн барьсан. Төслийг өргөн барихад УИХ-ын гишүүн З.Энхболд, С.Ламбаа нар ихээхэн идэвхи чармайлт гаргасан бөгөөд уг төсөл нь өөрөө нэлээд чамбай боловсруулагдсан байв. Төслийн гол үзэл баримтлал нь дараах зүйлст чиглэгдэж байв. Үүнд:

- ❖ Хүдрийн болон хатуу ашигт малтмал ашиглаж байгаа тохиолдолд хоногт 25 тонн хүдэр буюу ашигт малтмал олборлох, шороон орд ашиглаж байгаа үед хоногт 200 шоо метр хүртэлх уулын ажил гүйцэтгэх хүчин чадалтай уурхайг бичил уурхай хэмээн нэрлэх;
- ❖ Бичил уурхайн үйл ажиллагааг зохицуулах эрх, үүргийг сум, дүүргийн иргэдийн хурал, Засаг даргад өгөх;
- ❖ Бичил уурхайн үйл ажиллагааг мэргэжлийн зүгээс удирдах үүргийг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хүлээх;
- ❖ ХАМО-чид бичил уурхай эрхлэхийн тулд нэгдэж, Иргэний хуулийн 481.1-д заасны дагуу нөхөрлөл байгуулж, удирдлагаа сонгох;
- ❖ Том үйлдвэр, уурхайн аргаар ашиглахад эдийн засгийн үр ашиггүй орд илэрцэд, урьд өмнө нь ашигласан талбай дахь ашиглалтын болон баяжуулах технологийн хаягдал бүхий үүсмэл ордод, ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайн аль нэг хэсэгт лицензи эзэмшигчтэй тохиролцсоноор бичил уурхай эрхлэх зөвшөөрлийг олгох;
- ❖ Бичил уурхайд олгох талбайн хэмжээ 25 га-аас ихгүй байх;
- ❖ Сум /дүүрэг/-ын Засаг дарга нь ХАМО-дын байгуулсан нөхөрлөлтэй шууд, эсвэл нөхөрлөл болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй гурвалсан гэрээ байгуулах;
- ❖ Бичил уурхай нь тогтсон техник, технологийн дагуу аюулгүй ажиллагааны шаардлага хангасан нөхцөл

байдалд үр ашигтай үйл ажиллагаа эрхлэж, байгаль нийгмийн өмнө тодорхой хариуцлага хүлээдэг болох зэрэг үзэл баримтлалыг багтаасан.

“Бичил уурхайн тухай” хуулийн төсөл нь харьцангуй удаан хугацаанд, бодит судалгаануудад тулгуурлан, мэргэжлийн хүмүүс, мэргэшсэн хуульчдын оролцоотойгоор, ул суурьтай боловсруулагдаж, бичил уурхайн үйл ажиллагааг зохицуулахад шаардлагатай үзэл баримтлал, үндсэн зарчмуудыг товч тодорхой багтаасны дээр тодорхойлсон нэр томъёо, авч үзсэн хэмжээ, хэмжигдэхүүн хийгээд хууль зүйн зохицолдоо, хэл найруулгын хувьд өмнөх болон бусад төслүүдтэй харьцуулахад нэлээд боловсронгуй болсон учраас хууль болж батлагдаагүй хэдий ч бичил уурхайн харилцааг зохицуулах хэм хэмжээг цаашид тогтооход ач холбогдлоо өгөхүйц чухал баримт бичиг болсон юм.

Уг төслийн дутагдалтай тал нь бичил уурхайн нөхөрлөл Иргэний хуулийн 481.1-д заасан бүртгэгдээгүй нөхөрлөл байхаар заасан тул аж ахуйн нэгжийн орлогын албан татвар төлөх үүргээс чөлөөлсөнөөс уул уурхайн жижиг компаниудад бичил уурхай болж, татварын хөнгөлөлт эдлэх гэсэн хүсэл эрмэлзлэл төрүүлж болзошгүй байсанд оршино гэж зарим хүмүүс үзэж байжээ.

“Бичил уурхайн тухай хууль”-ийн төсөл батлагдаагүй шалтгаан нь уг төслийг өргөн барьсаны дараа Засгийн газраас өргөн барьсан “Ашигт малтмалыг гар үйлдвэрлэлийн аргаар олборлох тухай” хуулийн төсөлтэй нэгтгэснээс, зарим үзэл баримтлалууд нь алдагдсан явдал юм.

УИХ-ын Эдийн засгийн байнгын хороо дээрх 2 хуулийн төслийг тус бүрд нь авч хэлэлцээд 2 төслийг нэгтгэн боловсруулах шийдвэр гарсан байна. Үүний дагуу 2 төслийг нэгтгэж боловсруулсан “Бичил уурхайгаас ашигт малтмал олборлох тухай” гэсэн нэртэй хуулийн төсөл дээр хуулийн ажлын хэсэг болон Улсын Их Хурал дахь намын бүлгүүд ажиллаж, УИХ-ын 2006 оны намрын чуулганаар анхны хэлэлцүүлгийг хийсэн боловч дараагийн хэлэлцүүлэгт хараахан орж амжилгүй чуулган завсарлаж, 2007 онтой золгожээ.

ХАМО-дын үйл ажиллагааг зохицуулах хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэхийн төлөө 2005-2006 онд ҮХЯ, АМГТХЭГ, БУД төсөл болон бусад оролцогчдын хийсэн ажил, гаргасан идэвхи

чармайлтын үр дүн нь 2006 оны 07 сарын 08-ны өдөр УИХ-аар нэмэлт, өөрчлөлт оруулан баталсан “Ашигт малтмалын тухай” хуулийн 3 дугаар зүйлийн 2-т “Гар аргаар болон бичил уурхайгаас ашигт малтмал ашиглахтай холбогдсон харилцааг тусгай хуулиар зохицуулна” гэсэн ганц заалт оруулсан явдал байлаа. ХАМО-дын үйл ажиллагаатай холбогдсон харилцааг хуулиар зохицуулах нь зөв зүйтэй юм гэсэн үзэл санаа нийгэмд нэгэнт төлөвшсөн учраас “Ашигт малтмалын тухай” хуулинд тэр заалт орсон гэж үзэх үндэстэй.

2007 оны эхээр АМГТХЭГ-аас ТБУТ-ийн багт ажиллаж байсан ажилтнуудынхаа орон тоо, үйл ажиллагаанд тулгуурлан Бичил уурхайн хэлтэс зохион байгуулж ажиллуулсан нь ХАМО-дын үйл ажиллагааг бичил уурхай болгон зохион байгуулах хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх, бичил уурхайг мэргэжлийн удирдлагаар хангахад төр, засгийн оролцоог нэмэгдүүлсэн чухал ач холбогдолтой арга хэмжээ болсон юм. Тухайн үед АМГТХЭГ-ын даргаар (2004-2008 он) ажиллаж байсан Лу.Болд ХАМО-дын талаар ТБУТ-ийн хийж байгаа ажил, гүйцэтгэх үүрэгт өндөр ач холбогдол өгч бүхий л талаар дэмжиж, туслан хамтарч ажиллаж байсан бөгөөд АМГТХЭГ-ын даргын гадаад харилцаа эрхэлсэн зөвлөх бөгөөд ТБУТ-ийн Үндэсний захирлаар ажиллаж байсан Ч.Энхзаяа төслийн үйл ажиллагааг удирдан чиглүүлж, АМГТХЭГ-ын ажилтай уялдуулах, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэхэд анхаарал хандуулан ажиллаж байжээ.

2007 оны 01 сарын 03-нд УИХ-ын Эдийн засгийн байнгын хороо (ЭЗБХ)-ны хурлаар “Бичил уурхайгаас ашигт малтмал олборлох тухай” хуулийн төслийг хэлэлцээд үндсэн ба хатуу ашигт малтмалыг бичил уурхайгаар олборлох асуудлыг энэ хуулиар зохицуулахгүй байхаар засвар, өөрчлөлт оруулахыг ажлын хэсэгт даалгаж буцаасан байна.

2007 оны 01 сарын 15-нд УИХ-ын ЭЗБХ-оос бичил уурхайн хуулийн төслийн хэлэцүүлгийг хойшлуулж, УИХ-ын гишүүдийг ХАМО-чид бүхий орон нутгуудад явуулж, ХАМО-дын үйл ажиллагаатай газар дээр нь танилцуулахаар шийдвэрлэжээ. Уг шийдвэрийн дагуу УИХ-ын гишүүд орон нутагт ажиллаж байгаа хувиараа алт олборлогчдын амьдрал байдалтай танилцсан байна.

Хөдөө орон нутагт ажилласан УИХ-ын гишүүд ХАМО-

дыг нөхөрлөлийн зохион байгуулалтанд оруулж, тэдний үйл ажиллагааг бичил уурхайн хэлбэрээр зохицуулах нь илүү ач холбогдолтой юм гэсэн ойлголттой ирсэн бол зарим гишүүд арай өөр санал, сэтгэгдэлтэй байжээ. Тухайлбал: Архангай, Өвөрхангай аймагт ажилласан гишүүд ХАМО-дын ажиллах талбайг зааж олгоод, уг талбайг тойрсон хашаа барьж тэнд ажиллуулах, 100% төрийн өмчит компани байгуулж, уг ажлыг зохион байгуулна гэсэн гол үзэл баримтлал бүхий хуулийн төсөл боловсруулах санал гаргасан юм. Түүнийг “хашаанд оруулах” төсөл гэж тухайн үед хошигнон нэрлэж байв.

Үйлдвэр, худалдааны сайдын 2007 оны 09 сарын 27-ны өдрийн 251 тоот тушаалаар “Уул уурхайн тухай”, “Бичил уурхайн тухай”, “Хамгаалалтын ногоон бүсийн тухай” хуулийн төслүүдийг тодотгон боловсруулах ажлын хэсгийг байгуулсан байна. Тэрхүү ажлын хэсгийн ахлагчаар ҮХЯ-ны Геологи, уул уурхай, хүнд үйлдвэрийн газрын дарга Х.Бадамсүрэн томилогдон ажиллажээ. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд АМГТХЭГ-ын Бичил уурхайн хэлтсийн дарга Н.Батбаяр, ТБУТ-ийн техникийн эксперт Н.Даваасамбуу нар орж ажилласан байна. Энэ удаад “Бичил уурхайн тухай” хуулийн төсөлд зарим нэг өөрчлөлт, тодруулга хийхээс гадна дээр дурьдсан “хашаанд оруулах” хувилбараар хуулийн төсөл боловсруулах даалгавар өгөгдсөний дагуу “Бичил уурхайн тухай” бас нэгэн хуулийн хувилбар төсөл боловсруулсан боловч уг төслийн үндсэн үзэл баримтлал нь ХАМО-дын үйл ажиллагааг 100 хувь төрийн өмчийн компани удирдан зохицуулахад оршиж байсан бөгөөд хамаг ачаалал төрийн нуруун дээр ирэх, төрөөс их хэмжээний хөрөнгө гаргах шаардлагатай болох байсан учир энэ төсөл төдийлөн дэмжлэг авалгүйгээр тэгсхийгээд орхигдсон ажээ.

Ажлын хэсгийн гишүүд “Бичил уурхайг 2015 он хүртэл хөгжүүлэх дэд хөтөлбөр”-ийг боловсруулж Засгийн газраар батлуулах тухай, мөн “Бичил уурхайн тухай” хуулийн төсөл УИХ-аар хэлэлцэгдэж, батлагдах явц удаашралтай байгаа учир энэхүү хуулийн төсөлд тулгуурлан ХАМО-дын үйл ажиллагааг зохицуулах түр журмыг “Бичил уурхайн тухай хууль”-ийн төслийг үндэслэн боловсруулж, яамны сайдын тушаалаар батлуулан, хууль батлагдах хүртэл мөрдөх, үүний далимаар хуулийн төслийг амьдрал дээр түрших тухай саналуудыг гаргажээ. Тэдгээр саналын талаар харилцан ярилцаж байгаад түр журмыг

мөн Засгийн газраар батлуулахаар болж, ажлын хэсгийн гишүүд журмын төслийг боловсруулахаар тус тус тогтжээ. Тийм санал гарах болсон үндэслэл нь 2007 он бараг дуусаж байгаа, 2008 он сонгуулийн жил учраас УИХ-ын зарим гишүүд “Бичил уурхайн тухай хууль”-ийг батлахаас нэлээд цэрвэж байсны дээр гишүүдийн дунд бичил уурхайн зарим асуудлууд нэлээд маргаантай байсан зэрэг шалтгаанаас улбаалан хуулийг ойрын хугацаанд хэлэлцэж батлахгүй байх магадлал өндөр байжээ.

“Бичил уурхайг 2015 он хүртэл хөгжүүлэх дэд хөтөлбөр” болон “Хувиараа ашигт малтмал олборлож байгаа иргэдийн үйл ажиллагааг зохицуулах түр журам”-ын төсөл боловсруулах ажлыг ТБҮТ-ийн ажилтан Н.Даваасамбуу, Бичил уурхайн хэлтсийн дарга Н.Батбаяр, хуулийн ажилтан Т.Энхцэцэг нар голчлон хийж гүйцэтгэжээ.

2008 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр Монгол Улсын Засгийн Газрын “Хувиараа ашигт малтмал олборлож байгаа иргэдийн үйл ажиллагааг зохицуулах тухай” 28 дугаар тогтоол гарч, уг тогтоолд “. . . 5. *Иргэд хувиараа ашигт малтмал олборлож байгааг зохицуулах чиглэлээр журам болон дэд хөтөлбөрийн төсөл боловсруулж Засгийн газарт 2008 оны 3 дугаар сарын 1-ний дотор оруулахыг Үйлдвэр, худалдааны сайд Х.Наранхүүд даалгасугай.*” гэж заасан байна.

Үүний дараа Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн 71 дүгээр тогтоолоор “Бичил уурхайг 2015 он хүртэл хөгжүүлэх дэд хөтөлбөр”, 72 дугаар тогтоолоор “Хувиараа ашигт малтмал олборлож байгаа иргэдийн үйл ажиллагааг зохицуулах түр журам”-ыг тус тус баталж, хэрэгжүүлэх арга замыг заасан нь АМГ болон ТБҮТ-ийн багийн хамт олонд ихээхэн урам зориг өгч, дэд хөтөлбөр, түр журмыг хэрэгжүүлэх ажилдаа шамдан оржээ.

2008 оны 3 сарын 12-ны өдөр Монгол Улсын Засгийн газраас ХАМО-чидтой холбоотой бас нэгэн шийдвэр гаргасан нь “Налайхын нүүрсийг хувиараа ашиглаж байгаа иргэдийн үйл ажиллагааг зохицуулах тухай” 89 дүгээр тогтоол байлаа. Уг тогтоолоор Налайх дүүрэгт хувиараа нүүрс олборлож байгаа иргэдийг бүртгэх, ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдтэй гэрээгээр ажиллуулах, аюулгүй ажиллагааны дүрмийг мөрдүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авах, хувиараа нүүрс олборлох үйл ажиллагаанаас үүдэн бий болсон

цооног, нүүрсний амыг хааж, дахин ашиглах боломжгүй болгох, газрын нурал эвдрэлийн уршгаас үйлдвэрлэл, дэд бүтцийн байгууламжуудыг хамгаалах ажлыг хэрэгжүүлэх, дүүргийн ажилгүй иргэдийг хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын шугамаар ажилтай болгох бодлого хэрэгжүүлэх, байгаль орчныг нөхөн сэргээх үүрэг даалгаварыг холбогдох яамдын сайд нарт болон нийслэлийн Засаг даргад өгсөн байна.

2008 оны 3 сарын сүүлчээр ТБҮТ-ийн захиалгаар Хууль зүйн үндэсний төвийн эмхэтгэсэн “Бичил уурхайтай холбогдох эрх зүйн баримт бичгийн эмхэтгэл” ном хэвлэгдэн гарсан. Үг эмхэтгэлд 120 эрх зүйн актаас бичил уурхайтай холбогдох заалтуудыг түүвэрлэн авч оруулжээ.

2008 оны 4 сарын 8-ны өдөр Байгаль орчны сайдын “Мөнгөн усыг ашигт малтмалын олборлолт боловсруулалтанд ашиглахыг хориглох тухай” 135 тоот тушаал гарч, мөнгөн ус хэрэглэхийг мөн өдрөөс эхлэн хориглох, мөнгөн усны хэрэглээг хориглосон тухай хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлэх болон бусад холбогдох арга хэмжээг авч, хэрэгжүүлэх тухай заажээ.

2009 оны 3 сарын 2-ны өдөр Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын 28 тоот тушаалаар бичил уурхайн эрх зүйн орчныг сайжруулах, энэ чиглэлээр гадаад, дотоодын байгууллагаас хэрэгжүүлж байгаа төсөл, санхүүгийн эх үүсвэрийг үр ашигтай зарцуулах, бодлого, үйл ажиллагааг нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт нийцүүлэн зохицуулах асуудлыг боловсруулах ажлын хэсгийг байгуулсан байна. Ажлын хэсгийн ахлагчаар Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын орон тооны бус зөвлөх Б.Хулдорж томилогдон ажиллажээ. Ажлын хэсэгт ЭБЭХЯ, АМГ, ТБҮТ, МУУҮА, Дэлхийн банк, Азийн сан, НҮБ-ын Хүн амын сан, ОУХБ зэрэг төрийн болон ТББ, донор байгууллагын төлөөллөөс гадна олон улсын зөвлөх Лаура Барретто болон бичил уурхайчдын төлөөлөл орж ажилласан байна.

Бичил уурхайн эрх зүйн орчныг сайжруулахтай холбогдуулан дээрх тушаалаар өгсөн үүргийн дагуу ажлын хэсгийн гишүүн, олон улсын хуулийн зөвлөх Канад улсын иргэн Лаура Барретто “Хувиараа болон бичил уурхайгаас ашигт малтмал олборлох тухай” гэсэн нэртэй хуулийн төсөл боловсруулсан байна.

Лаура Барреттогийн боловсруулсан “Хувиараа болон

бичил уурхайгаас ашигт малтмал олборлох тухай” хуулийн төслийн гол үзэл баримтлал нь ХАМО, бичил уурхай эрхлэгчид, жижиг уурхай эрхлэгчдийн аль алиныг (гурвууланг) нь шороон орд, үндсэн ордын илэрц, үүсмэл ордоос ашигт малтмал олборлохыг тусгай зөвшөөрөл олгох журмаар зөвшөөрч, 10-1000 га газар олгохын дээр тус тусынх нь хоногт гүйцэтгэх ажлын бүтээмжийг (25-2500 шоо метр шороо, 5-500 тн хүдэр) зааж өгсөн ба тусгай зөвшөөрлийг орон нутгийн уул уурхайн байгууллага олгохоос гадна байгаль орчны тусгай шаардлага тавьдаг байхаар боловсруулсан байжээ.

Төслийн авууштай тал нь бичил уурхай, жижиг уурхайн хоногийн бүтээмжийг нэлээд бололцоотой сонгосон, бичил уурхай, жижиг уурхайд олгох талбайг нэлээд том байхаар төсөлдөө тусгасан байсан. Гэвч уг хуулийн төслийн үзэл баримтлал нь Монголын нөхцөлд төдийлөн таарахааргүй байна гэж эрдэс баялагийн салбарын бодлого боловсруулах, хэрэгжүүлэх байгууллагын мэргэжилтнүүд үзжээ.

Иймд Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 72 дугаар тогтоолоор батлагдсан “Хувиараа ашигт малтмал олборлож байгаа иргэдийн үйл ажиллагааг зохицуулах түр журам”-ыг хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байгаа асуудлыг шийдвэрлэх, эрх зүйн орчин бүрдүүлэх талаар санал боловсруулах ажлын хэсгийг Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын 2009 оны 5 сарын 1-ний өдрийн 107 тоот тушаалаар байгуулсан юм. Эрдэс баялаг, эрчим хүчний яам (ЭБЭХЯ)-ны Уул уурхай, хүнд үйлдвэрийн бодлогын газрын орлогч дарга Ч.Цогтбаатараар ахлуулсан ажлын хэсэгт ЭБЭХЯ болон АМГ, ТБУТ-ийн холбогдох мэргэжлийн хүмүүс голчлон ажилласан билээ.

Ажлын хэсэг ажиллах явцдаа ХАМО-дын үйл ажиллагааг Засгийн газрын баталсан журмаар зохицуулдаг байх, орон нутаг бичил уурхайн зориулалтаар орон нутгийн тусгай хэрэгцээнд газар авдаг эрхтэй байхаар зохицуулалт хийх нь зүйтэй гэсэн нэгдсэн дүгнэлтэнд хүрч, “Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”, “Газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай”, “Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ эрхлэгч иргэний албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай” хуулийн төслүүдийг боловсруулсан байна.



УИХ-ын гишүүдийн хэлэлцүүлэг 2010.01.07

Тэдгээр хууль, журмын төслийг боловсруулсны дараа 2010 оны 1 сарын 7-ны өдөр ТБУТ-өөс Эрдэс баялаг, эрчим хүчний сайд болон ажлын хэсгийн гишүүдтэй хамтран “Бичил уурхайн тухай” хуулийн төсөл санаачилсан УИХ-ын гишүүд болон УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны гишүүдийн дунд хэлэлцүүлэг зохион байгуулж, хууль журмын төслийг танилцуулсан юм. Хэлэлцүүлэгт оролцогсад 2009-2010 оны өвөлжилтийн хүндрэлтэй байдал, цас зуд болон “Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох” тухай хууль батлагдсантай холбогдуулан олон ашигт малтмалын тусгай зөвшөөрөл цуцлагдах болсон учир хувиараа ашигт малтмал олборлогч иргэд, лиценз нь цуцлагдсан аж ахуйн нэгжүүд олноор бичил уурхайн үйл ажиллагаанд татагдан орох магадлалтай байгаа нөхцөл байдлыг харгалзан яаралтай эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай байна гэдэг дээр санал нэгдсэн байна. Хэлэлцүүлгийн үр дүнд ажлын хэсгийн боловсруулсан хуулиудын төслийг сайжруулах, улмаар УИХ-ын хаврын чуулганаар хэлэлцүүлэхээр ажиллах, бичил уурхайг Засгийн газрын журмаар зохицуулах нь зүйтэй юм гэдэг дээр үндсэндээ санал нэгдсэн байна.

Ажлын хэсгийн боловсруулсан Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг

УИХ-ын 2010 оны 06 сарын 25-ын өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хийж эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн билээ. УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлэг явуулах үед бичил уурхай гэж юуг ойлгох, Газрын тухай хуулийн 16.1.11-д заасан зориулалтаар бичил уурхайн газрыг орон нутгийн тусгай хэрэгцээнд авах нь зүйтэй эсэх болон Засгийн газраас журам батлан гаргахдаа химийн хорт бодис, мөнгөн ус, цианит, тэсрэх дэлбэрэх бодис ашиглах, үндсэн ордыг хамруулах, далд уурхайг ашиглах эсэх, хөдөлмөр аюулгүй ажиллагаа зэрэг асуудлуудыг онцгой анхаарч төслийг гүйцээн боловсруулан эцсийн хэлэлцүүлэгт оруулж ирэх чиглэл өгсөн билээ. Энэ чиглэлийн дагуу хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэх Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Даш.Зоригт, мөн яамны Уул уурхай, хүнд үйлдвэрийн газрын орлогч дарга Ч.Цогтбаатар, УИХ-ын Тамгын газрын Эрх зүй, хууль тогтоомжийн хэлтсийн дарга Д.Насанжаргал, Э.Түвшинжаргал, УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны зөвлөх Ж.Батсайхан, референт Д.Цэцэгмаа, Ш.Ариунжаргал нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг ажилласан бөгөөд ажлын хэсгийн ахлагчаар УИХ-ын гишүүн Ж.Батсуурь ажилласан байна.

Ажлын хэсэг УИХ-ын нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр дэмжигдсэн саналыг төсөлд нэмж тусгасны зэрэгцээ агуулгын болон найруулгын шинжтэй, хууль тогтоомжийн бичлэгийн болон техникийн шинжтэй зарим засвар хийж, төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэжээ.

Ажлын хэсгийн гүйцээн боловсруулсан “Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хууль, “Газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай” хуулийг Улсын Их Хуралын 2010 оны 7 дугаар сарын 1-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар, “Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ эрхлэгч иргэний албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай” хуулийг Улсын Их Хуралын 2010 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн хуралдаанаар тус тус хэлэлцэн баталжээ. Ийнхүү 2010 оны 5 сарын 24-ний өдөр Засгийн газраас өргөн мэдүүлсэн хуулиуд батлагдахад УИХ-ын гишүүн, Эдийн засгийн байнгын хорооны дарга Ц.Баярсайхан, ажлын хэсгийн ахлагчаар ажилласан УИХ-ын гишүүн Ж.Батсуурь, УИХ-ын гишүүн, Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт нар ихээхэн идэвх зүтгэл гарган ажилласан билээ.

“Хувиараа ашигт малтмал олборлогч иргэдийн үйл ажиллагааг зохицуулах түр журам” хэрэгжиж эхлээд жил гаруйн хугацаа өнгөрсний дараа 2008 оны сүүлээр тэрхүү журмын хэрэгжилтэнд АМГТХЭГ болон ТБУТ хамтран үнэлгээ хийж үзэхэд уг журмаар бичил уурхай эрхлэх газрын асуудлыг зохицуулж чадахгүй байгаагаас түүнийг хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байна гэсэн дүгнэлтэнд хүрсэн байв.

Иймд “Хувиараа ашигт малтмал олборлож байгаа иргэдийн үйл ажиллагааг зохицуулах түр журам”-ын хэрэгжилттэй холбогдуулан хэлэлцүүлгийн үеэр хувиараа ашигт малтмал олборлогчид, төрийн ба төрийн бус байгууллагын ажилтнууд, орон нутгийн иргэд, удирдлагуудын өгсөн санал, зөвлөмж, дүгнэлт, олон улсын зөвлөхүүдийн хийсэн дүн шинжилгээ, санал зөвлөмжид тулгуурлан “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагааг зохицуулах журам”-ын шинэ төслийг боловсруулсан байна.

Мөн түүнчлэн ТБУТ-ийн баг АМГ-тай хамтран дээрх хууль, журмын төслөөр холбогдох яам, агентлаг, гадаад дотоодын ТББ-ын төлөөлөл, орон нутгийн засаг захиргааны ажилтнууд болон бичил уурхайчдын дунд олон удаа хэлэлцүүлэг, ярилцлага зохион байгуулж санаа бодлыг нь авч ажлын хэсэгт хүргүүлсэнээр хууль, журмын төсөлд тодорхой саналууд тусгагдсан болно. Чухамдаа холбогдох бүх л субъектуудын төлөөллүүдийн оролцоог хангаж, тэдний санал, байр суурийг зохих хэмжээгээр тусгаснаараа энэ төсөл өмнөх төслүүдээс онцлог юм.

Засгийн газрын 2010 оны 12 дугаар 1 -ны өдрийн 308 тоот тогтоолоор “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам” батлагдсан байна.

Монгол Улсын Үйлдвэр, Худалдааны Яам (хуучин нэрээр) болон Эрдэс баялаг, Эрчим хүчний яам нь геологи, уул уурхай, хүнд үйлдвэрийн асуудал хариуцсан төрийн төв байгууллагын хувьд Монгол Улсад иргэд хувиараа ашигт малтмал олборлох үйл ажиллагаа бий болсон цагаас эхлэн тэдний үйл ажиллагааг анхааралдаа авч, түүний хууль, эрх зүйн орчныг албан ёсоор бүрдүүлэхийн төлөө санаачлагатай ажиллаж ирсэний үр дүнд бичил уурхайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагааны эрх зүйн орчин бүрдсэн юм.

Бичил уурхайн үйл ажиллагааг зохицуулах хууль, эрх зүйн

орчныг бүрдүүлэх ажлын үүд хаалгыг нээх, эн тэргүүний алхам болох хуулиар хүлээн зөвшөөрөх тухай асуудал ийнхүү удаан хугацаагаар сунжирсан нь дараах учир шалтгаантай байсан гэж үзэж болно. Үүнд:

1. Улс орон төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцооноос зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийн үеийн улстөр, нийгэм, эдийн засгийн ороо бусгаа байдал голлон нөлөөлсөн;
2. ХАМО-чид бий болж байх эхэн үед уг үзэгдэл нь түр зуурын, хууль бус үйл ажиллагаа учраас тухайн үед хүчин төгөлдөр үйлчилж байсан хууль, эрх зүйн актуудаар хязгаарлаж болно хэмээн үзэж үл тоомсорлосноос цаг их алдсан;
3. Ардчиллыг буруу ойлгосон анархист үзэгдлүүдийн нөлөөгөөр нийгмийн гишүүдийн шинж чанар ихэд өөрчлөгдсөнийг үл тооцон, хуучны адил дуулгавартай байх мэтээр ойлгож, асуудлыг салбарын яам, агентлагийн түвшинд журам гаргах төдийхнөөр зохицуулж болох мэтээр ойлгож байснаас хугацаа алдсан;
4. Эл үзэгдэл нь нийгэм, эдийн засгийн тухайн үеийн нөхцөл байдлын зүй тогтолт шаардлага, ажилгүйдэл, мөнгөний хомсдол, ган зудын гамшгаас үүдэн бий болж, байгаль, нийгмийн олон асуудлуудыг хөндөж, хамрагдах нийгмийн гишүүдийн тоо, эзлэх орон зай, тархалтын хувьд хүрээгээ асар ихээр тэлж, хууль ёсны зохицуулалт шаардлагатай болсныг төр, засгийн зүгээс хүлээн зөвшөөрөх хүртэл даруй 5-6 жил өнгөрсөн;
5. ХАМО-чдын үйл ажиллагаа нийгэмд олон тооны сөрөг үр дагаварыг бий болгож байсныг таслан зогсоох шаардлагатай, тэдний ажиллагааг хуулиар яв ч зөвшөөрч болохгүй хэмээн хууль тогтоох дээд байгууллагын үе үеийн гишүүдийн дийлэнхи олонхи нь үздэг байсантай холбоотой;
6. Тухайн үед боловсруулсан хууль, журмын төслүүд дутуу дулимаг, логик холбоо, алсын хараа дутмаг, үүссэн нөхцөл байдлыг бодитой тооцоогүй, хэрэгжих магадлал бага төслүүд байсан учир УИХ-ын гишүүдэд зөрүүтэй, ташаа ойлголт төрүүлэх тохиолдлууд байснаас гадна хуулийн төслүүдийг УИХ-ын Намын бүлгүүд, Байнгын хороодын хурал, нэгдсэн чуулган дээр хэлэлцэх үед тайлбарлан ойлгуулах

мэдлэг, зүтгэл, сэтгэл тухайн үеийн Засгийн газрын сайд нар, салбарын яамны ажилтнуудын зүгээс ихээхэн учир дутагдалтай байсан;

7. Зарим тохиолдолд хуулийн төслийн өөр өөр хувилбарууд зэрэгцэн хэлэлцэгдэж, хууль тогтоогч нар учрыг нь олоход төвөгтэй байдал үүсдэг байсантай холбоотой;
8. Өнгөрсөн хугацаанд УИХ-ыг сонгох 2000, 2004, 2008 оны ээлжит сонгууль таарч байсан тул үе үеийн хууль тогтоогч нарын олонхи нь хууль бус үйл ажиллагааг дэмжих, ээдрээтэй асуудалд орооцолдохоос зайлсхийж байснаас лав л бүтэн 3 жилийг алдсан гэж үзэж болно.

Тухайн үед боловсруулагдсан ХАМО-дын үйл ажиллагааг зохицуулахтай холбоотой хуулийн төслүүдийг шат шатны хурал, чуулганаар хэлэлцэх явцад дараах асуудлуудад олонхи хууль тогтоогчид шүүмжлэлтэй, эргэлзээтэй хандаж, тодорхой шийдэл, нэгдсэн саналд хүрч чаддаггүй байснаас хэлэлцүүлэг хойшлох, хуулийн төслийг буцаах тохиолдлууд гарч байжээ. Үүнд:

1. ХАМО-дыг нөхөрлөлийн зохион байгуулалтанд оруулаад, гарт нь хүрз, жоотуу бариулаад одоо байгаагаар нь байлгаж байх, ХАМО-дыг бичил уурхайн үйл ажиллагаанд шилжүүлж, тэдний хөгжих дэвжих замыг нээж өгөх гэсэн 2 чиглэлийн үзэл баримтлалыг ялгаж салгахгүй байх явдал байсан. Зарим нь ахиж дэвжих, хөгжих бололцоо олгож болохгүй, зохион байгуулалтанд оруулж одоогийн хэмжээнд л байлгах арга хэмжээ авна гэж байхад зарим нь одоогийн байгаа байдлаар нь зохион байгуулалтанд оруулах төдий байдлаар хуульчилж яасан ч болохгүй гэж үздэг байв.
2. Бичил уурхайчид далд уурхайн аргаар ажиллах, ажиллахгүй тухай асуудал;
3. Үндсэн ордыг бичил уурхайгаар олборлох эсэх тухай асуудал;
4. Бичил уурхайн тэсэлгээний асуудлыг хэрхэх тухай;
5. Бичил уурхайд хэрэглэх тоног төхөөрөмжийн хүчин чадалд хязгаар тогтоох эсэх тухай;
6. Бичил уурхайд олгох талбайн хэмжээний асуудал;
7. Бичил уурхайн эрүүл ахуй, аюулгүй ажиллагааг хэн хариуцах тухай;

8. Нөхөрлөлийн гишүүдийн тооны тухай;
9. Бичил уурхайчдын татвар, нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын тухай асуудал;
10. Байгаль орчны нөхөн сэргээлийг хэрхэн гүйцэтгэх, түүний зардал мөнгөний тухай асуудлууд;
11. Мөнгөн усны хэрэглээтэй холбоотой асуудал;
12. Малталтын гүний зөвшөөрөгдөх хэмжээ ямар байх зэрэг асуудлууд хэлэлцүүлгийн үеэр гол анхаарал татдаг байсан.

Монгол Улсын хувьд иргэд хувиараа ашигт малтмал олборлох болон бичил уурхайн үйл ажиллагаа нь шинэ зүйл байснаас тухайн үед тэр бүгдэд хариулах оновчтой хариулт, олон улсын туршлагаас авч хэрэглэх бэлэн жор хэнд маань ч байсангүй.

Бичил уурхайн хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр эрдэс баялагийн салбарын яам, агентлагийн хувьд ҮХЯ, ЭБЭХЯ, АМГТХЭГ, АМГ голлон ажилаж байсан бөгөөд ТБУТ үйл ажиллагаагаа эхэлсэн цагаас хойш бүх талын дэмжлэг үзүүлж хамтран ажилласаар ирсэн байна.

Бичил уурхайн хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэхийн төлөө Тогтвортой бичил уурхай төсөл, АМГ-ын Бичил уурхайн тасгийн хамт олон 5 жилийн туршид нэг баг болон ажиллаж, олон төрлийн хэлэлцүүлэг, уулзалт, ярилцлага, хурал, семинар, зөвлөлгөөн, аяллыг зохион байгуулж, төр, олон нийт, орон нутгийн байгууллагууд болон бичил уурхайчидтай хамтран ажилласан нь бичил уурхайн хууль эрх зүйн орчин бүрдэхэд чухал үүрэг гүйцэтгэжээ. Мөн түүнчлэн бичил уурхайн хууль, эрх зүйн орчны талаарх олон улсын сайн туршлагаас суралцах, өөрийн оронд нутагшуулах зорилгоор гадаад харилцаа холбоогоог өргөжүүлэх чиглэлээр ТБУТ-ийн зүгээс анхаарч ажиллаж иржээ. Энэ ажлын хүрээнд ТБУТ-өөс Бичил уурхайг дэмжих олон улсын нийгэмлэгийн (CASM) үйл ажиллагаанд 2006 оноос хойш идэвхитэй оролцож, бичил уурхайн гадаад харилцаа, түншлэлийг хөгжүүлж байна. 2007 онд Дэлхийн банктай хамтран Улаанбаатар хотноо Бичил уурхайг дэмжих олон улсын нийгэмлэгийн VII бага хурлыг амжилттай зохион байгуулсан байна.



CASM VII хурал, Улаанбаатар хот, 2007.09.07-12 өдрүүд

Үүнээс гадна ЭБЭХЯ-ны Уул уурхай, хүнд үйлдвэрийн бодлогын газартай хамтран “Бичил уурхай ба хөдөөгийн хөгжил” үндэсний зөвлөлгөөнийг 2009 оны 10 дугаар сарын 13-нд Улаанбаатар хотноо төрийн ордонд зохион байгуулж, ХАМО-дын хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх талаар тусгайлан хэлэлцэж, ХАМО-чид, ОУ-ын байгууллага, төсөл хөтөлбөрүүд, Төрийн бус байгууллага, УИХ-ын гишүүд, Засгийн газар, орон нутгийн төр, захиргааны байгууллагуудад хандаж зөвлөмж, уриалга гаргасан юм. Энэхүү зөвлөлгөөн хууль тогтоогч болон бодлого боловсруулагч нарт бичил уурхайг зохицуулах хууль, журмыг яаралтай баталж өгөх хэрэгтэй юм байна, энэ үзэгдэл яваандаа алга болох түр зуурын юм уу, эсвэл хүчээр хориглоод үр дүнд хүрэх юм биш байна гэдэг зөв ойлголтыг өгсөнөөрөө ач холбогдолтой арга хэмжээ болжээ. Энэхүү зөвлөлгөөнийг УИХ-ын гишүүн Г.Занданшатар, ТБҮТ-ийн зохицуулагч П.Үржинлхүндэв нар санаачлан Монгол Улсын Ерөнхий сайдын ивээл дор зохион байгуулсан бөгөөд зөвлөлгөөний хэлэлцсэн асуудлууд оновчтой, тодорхой байсан нь бичил уурхайн хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх цаашдын ажилд томоохон түлхэц өгсөн юм.



“Бичил уурхай ба хөдөөгийн хөгжил” үндэсний зөвлөлгөөн, Улаанбаатар хот,
2009.10.13

Бичил уурхайн хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаатай холбоотой асуудал бүх талуудын анхаарлын төвд байсаар ирсэн бөгөөд хууль, эрх зүйн орчин бүрдүүлэх үйл явцтай хамт яригдаж ирсэн юм. Энэ утгаар ТБУТ-ийн захиалгаар ШУТИС-ийн Уул уурхайн инженерийн сургуулийн тэргүүлэх профессор, доктор Ж.Цэвэгмид ахлагчтай ажлын хэсэг “Бичил уурхайн аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм, заавар”-ыг 2007 онд боловсруулсан нь АМГТХЭГ-ын даргын 2008 оны 06 сарын 02-ны өдрийн 253 дугаар тушаалаар батлагдсан байна.

“Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-д геологи уул, уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас энэхүү журмыг дагаж мөрдөхөд шаардлагатай дүрэм, заавар, маягт, гэрээний загварыг боловсруулж батлахаар заасан байна. Энэ дагуу ЭБЭХЯ, АМГ болон төслийн баг хамтран “Ашигт малтмал олборлох тухай гэрээ байгуулах өргөдөл”, “Ашигт малтмал олборлох гэрээ”, “Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайгаас бичил уурхайгаар ашигт малтмал олборлох тухай гурвалсан гэрээ”-ний загвар, “Бичил уурхайн нөхөн сэргээлтийн заавар”, “Бичил уурхайн хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм”, “Бичил уурхай эрхлэгчдийн үйл ажиллагааны талаархи мэдээллийн маягт”, “Бичил уурхайн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх болон хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны

хүрээнд авах арга хэмжээний төлөвлөгөө, тайлангийн маягт” зэргийг холбогдох мэргэжлийн хүмүүс боловсруулж АМГ-ын дарга 2011 оны 4 сарын 21-ний өдрийн 153 дугаар тушаалаар баталгаажуулсан бөгөөд тэдгээр баримт бичиг мөрдөгдөж байна. Түүнчлэн ТБҮТ-өөс Монгол Улсын Үүл уурхайн аврах алба (УУАА)-тай бичил уурхайн аюулгүй ажиллагааны талаар 2006 оноос эхлэн гэрээ байгуулан хамтран ажиллаж, хөдөлгөөнт аврах багийг зохион байгуулж, Монгол Улсын бичил уурхайчид ажиллаж буй бүх нутаг дэвсгэрт хүрч ажиллан, аюулгүй ажиллагааны дүрэм, зааврыг тайлбарлан таниулах, сурталчлах, аюулгүй ажиллагааны арга барилд сургах, ослын үеийн аврах ажиллагааны сургалт, үзүүлэх сургуулиудыг зохион байгуулсаар ирлээ.



ГУРАВ. БИЧИЛ УУРХАЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ӨНӨӨГИЙН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН, ТҮҮНИЙГ ОЙЛГОХ НЬ

Ашигт малтмалын тухай хууль болон Газрын тухай хуулийн Бичил уурхайн талаарх шинэ зохицуулалтын онцлог нь:

1. Ашигт малтмалын тухай хуулийн 4.1.2-т “бичил уурхай гэж Газрын тухай хуулийн 16.1.11-д заасан зориулалтаар олгосон ашигт малтмалын үйлдвэрлэлийн бус агуулгатай эдийн засгийн үр ашиггүй орд, ашиглалтын болон технологийн хаягдлаар бий болсон үүсмэл орд, илрэл бүхий талбайд ашигт малтмал олборлох зорилгоор Иргэний хуулийн 481.1-д заасны дагуу бүртгэгдээгүй нөхөрлөлийн хэлбэрээр зохион байгуулагдсан иргэдийн эрхэлж байгаа үйл ажиллагааг” хэлнэ гэж заасан. Тийнхүү Ашигт малтмалын тухай хуульд **“бичил уурхай”** гэдэг нэр томъёог оруулж өгсөн нь бичил уурхайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагаа хууль тогтоомжоор хүлээн зөвшөөрөгдсөн, хууль ёсны үйл ажиллагаа болсон гэсэн үг юм. Энэ тодорхойлолтод зааснаар бичил уурхайгаар ашигт малтмал олборлохын тулд “Бүртгэгдээгүй нөхөрлөл”-ийн хэлбэрээр зохион байгуулагдсан байх ёстой.
2. Газрын тухай хуулийн 16.1.11-д зааснаар аймаг, сүм, дүүрэг бичил уурхайн зориулалтаар газар олгохдоо орон нутгийн тусгай хэрэгцээнд газар авах эрхтэй болсон. Ямар газраас бичил уурхайн зориулалтаар олгох газрыг сонгох вэ гэдгийг Ашигт малтмалын тухай хуульд зааж өгсөн. Үүнд:
 - Ашигт малтмалын үйлдвэрлэлийн бус агуулгатай, эдийн засгийн үр ашиггүй орд,
 - Ашиглалтын болон технологийн хаягдлаар бий болсон үүсмэл орд, илрэл бүхий талбай,
3. Ашигт малтмалын хуулийн 12.1.5-д заасны дагуу бичил уурхайн зориулалтаар орон нутгийн тусгай хэрэгцээнд

авах газрыг ИТХ сонгож, солбицолыг тогтоох, сонгосон газрын талаар бичил уурхайн зориулалтаар тусгай хэрэгцээнд авч болох эсэх талаар дүгнэлт гаргуулах тухай хүсэлтийг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад гаргахыг сум, дүүргийн Засаг даргад зөвшөөрсөн тухай шийдвэр гаргахаар заажээ.

4. Ашигт малтмалын хуулийн 11.1.23-т геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага уг хүсэлтийг хүлээн аваад орон нутгийн бичил уурхайн зориулалтаар сонгосон газар нь бусад хуулиар ашигт малтмал олборлохыг хориглосон, өөр зориулалтаар тусгай хэрэгцээнд авсан, улсын нөөцөд авсан, эсхүл бусдад тусгай зөвшөөрлөөр олгосон талбайтай давхцаж байгаа эсэх талаар шалгаж үзээд, хэрэв боломжтой бол газрын хэмжээ, хил хязгаарыг тогтоож, дүгнэлт гаргаж өгөхөөр заасан байна.
5. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагааг Засгийн газраас баталсан журмаар зохицуулахаар Ашигт малтмалын тухай хуулийн 3.2-т заажээ.
6. Засгийн газраас баталсан бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмыг зөрчсөн этгээдэд Ашигт малтмалын тухай хуулийн 66.1.9-д заасны дагуу хариуцлага хүлээлгэхээр зохицуулалт хийсэн байна.

“Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-д бичил уурхай эрхлэх иргэдийн зохион байгуулалт, тэдэнд тавих шаардлага, бичил уурхайгаар ашигт малтмал олборлох гэрээ байгуулах өргөдлийг хэнд гаргах, олборлолт явуулах талбайн хэмжээ, хязгаар ямар байх, далд уурхай ашиглах нөхцөл, үндсэн ордын хүдрийг хаана баяжуулах, олборлосон ашигт малтмалыг хэрхэн борлуулах, олборлолт явуулсан талбайн нөхөн сэргээлтийг хэн хариуцах, бичил уурхайн үйл ажиллагаанд юуг хориглох зэргийг нарийвчлан зааж өгсөн байгаа. Мөн түүнчлэн бичил уурхайн талаар сум, дүүргийн Засаг дарга, ИТХ болон геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, бичил уурхайн нөхөрлөл ямар эрх, үүрэгтэй байх талаар нэг бүрчлэн тусгасан байна.

Тийнхүү Монгол Улсын Их Хурлаас “Газрын тухай”, “Ашигт малтмалын тухай”, “Орлогыг нь тухай бүр тодорхойлох

боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэний орлогын албан татварын тухай” хуулиудад бичил уурхайтай холбоотой заалтууд оруулан баталснаар ХАМО-чид үйл ажиллагаагаа бичил уурхай болгон өөрчилж, *эрх чөлөөтэй* хөдөлмөрлөх хууль ёсны *газартай, албан ёсны ажлын байртай*, үйл ажиллагааг нь зохицуулах *хуультай*, олсон орлогоосоо өөрийн болон бусдын сайн сайхны тулд хандивлах *эрх, үүрэгтэй* иргэн боллоо.

Төр, засгаас ХАМО-дыг хуулийн тийнхүү зохицуулалтанд оруулж, нийгэмд зөвшөөрсөн, бүрэн эрхт иргэн болох үүд хаалгыг нь цэлийтэл нээж өглөө. ХАМО-чид Монгол Улсын хуулиар зөвшөөрсөн **БИЧИЛ УУРХАЙЧИД** болох *хууль эрх зүйн орчин* ийнхүү бүрдлээ. Энэ орчныг ерөнхийд нь:

- Ашигт малтмал олборлож байгаагийнх нь хувьд “Ашигт малтмалын тухай” хуулиар зохицуулна.
- Газрын тухай хуулиар бичил уурхайд зориулан газар олгохыг зөвшөөрнө.
- Тэр газар нь ашигт малтмалын үйлдвэрлэлийн бус агуулгатай эдийн засгийн үр ашиггүй орд, илрэл, эсвэл уурхайн ашиглалтын болон технологийн хаягдлаар бий болсон үүсмэл орд, илрэл бүхий талбай байна.
- Олгох газрыг сум, дүүргийн ИТХ сонгох бөгөөд бичил уурхайн зориулалтаар ашиглах боломжтой эсэх талаарх шийдвэрийг төрийн захиргааны байгууллага гаргана.
- ХАМО-чид Иргэний хуульд заасны дагуу нэгдэж, нөхөрлөлийн зохион байгуулалтанд орсноор бичил уурхай эрхлэх өргөдөл гаргах, улмаар ашигт малтмал олборлох эрхтэй болно.
- Бичил уурхайчид нь тодорхой үйл ажиллагаа эрхлэж, орлого олж байгаа Монгол Улсын иргэний хувьд татвар төлнө.
- Бичил уурхайтай холбогдсон харилцааг Засгийн газрын баталсан журмаар зохицуулна.
- Хууль зөрчвөл торгууль шийтгэл хүлээнэ гэж тус тус ойлгоно.
- Бичил уурхайн хууль эрх зүйн орчин нэгэнт бүрдсэн тул цаашид сайжруулах ажлыг байнга хийх ёстой гэж ойлговол зохино.

Үүнийг ХАМО-чид ямар байдлаар ойлгох вэ гэвэл:

- Юуны түрүүнд хуучин ХАМО-дын үе өнгөрлөө гэж,
- Хууль, журмын учрыг түргэн ойлгож, мэдэх нь дээр гэж,
- Хуультай болсон учир хууль, журмаа сахидаг байх ёстой гэж,
- Улс орондоо бүртгэлтэй, иргэний бичиг баримт бүхий иргэн байх ёстой гэж,
- Нөхөрлөлд хамрагдаж, бичил уурхайчин болох ёстой гэж,
- Осол эндэлгүй сайн ажиллах ёстой гэж,
- Албан ёсны ажлын байртай боллоо гэж,
- Тогтмол орлогын эх үүсвэртэй боллоо гэж,
- Орлогоо зөв тооцож, амьдарлаа дээшлүүлэх, хуримтлал бий болгох ёстой гэж,
- Ядуу амьдарч болохгүй шүү дээ гэж,
- Татвараа төлж, бусад хууль, журмыг сахиж, нийгмийнхээ өмнө үүрэг хүлээх ёстой гэж,
- Хишиг буяныг нь хүртэж буй байгаль дэлхийгээ хайрлаж нөхөн сэргээлтээ номын ёсоор хийж, орчноо цэвэр байлгах ёстой гэж ойлгох ёстой.

Орон нутгийн төр, захиргааны байгууллага хэрхэн ойлговол зохилтойг дурьдвал:

- Маш их эрх мэдэл гэж,
- Сайтар биелүүлбэл зохих үүрэг гэж,
- Орон нутагт тань ямар эрдэс, баялаг ямар хэмжээгээр байгааг түргэн сайн судалж мэдэх шаардлага гэж,
- Уугуул нутгаа удирдах ухаан гэж,
- Байгалиа хамгаалах дэмжлэг гэж,
- Ажлын байр нэмэгдүүлэх боломж гэж,
- Ард иргэдийнхээ амьдарлыг дээшлүүлэх завшаан гэж,
- Нутаг орноо хөгжүүлэхэд нэмэрлэх нөөц бололцоо гэж,
- Эзэд нь та нар өөрсдөө учраас эндэж болохгүй хариуцлага гэж,
- Нутаг усныхаа ах дүү нарын төлөө гаргах их сэтгэл гэж,
- Ухаалаг, алсын хараатай байх санамж гэж ойлгоно.

Төрийн захиргааны болон хэрэгжүүлэгч, дэмжигч байгууллагуудын ойлголт ямар байхыг тунгаавал:

- Санаа амрах шалтгаан биш гэж,
- Ажлын эхлэл гэж,
- Хэрэгжүүлэх арга, ухаанаа олох хэрэгтэй гэж,
- Хэрэгжилтийг эрч хүчтэй, өргөн цар хүрээтэй зохион байгуулах шаардлагатай гэж,
- Хуучин ХАМО-чид байх ёсгүй гэж,
- Уян хатан байх ёстой гэж,
- Бичил уурхайн талаар баримтлах тодорхой бодлоготой байж, алсыг харах үүрэг гэж ойлгох учиртай болж байна.

Монгол Улсын Засгийн Газраас “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ыг баталж өгснөөр бичил уурхайн эрх зүйн орчны гол цөм нь бий болж байгаа юм. Өмнөх хэсэгт бичсэнчлэн бичил уурхайн хууль зүйн орчин бүрдчихсэн байгаа өнөөгийн нөхцөлд нийгэмд нийтлэг үйлчилж байгаа эрх зүйн хэм хэмжээний актуудын цогц бүрдэл нь тэрхүү цөмийг хүрээлэн авч бичил уурхайн эрх зүйн орчныг аяндаа бүрдүүлнэ. Учир нь бичил уурхайчид бол монголын нийгмийн тэгш эрхэт гишүүдийн нэг хэсэг байгаатай холбоотой юм.

Бичил уурхайн эрх зүйн орчны цөм нь болж байгаа “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагааг зохицуулах журам”-ыг уншиж судлах, хэрэгжүүлэх, дагаж мөрдөх, сургалт сурталчилгааг өргөн хийх, бусад эрх зүйн нөхцлүүдтэй сайтар уялдуулан зохистой ашиглах нь бичил уурхайчид, олон нийт, шат шатны төр, захиргааны байгууллагуудын үүрэг болж байна.

Эрх зүйн чиг үүргийн хувьд авч үзвэл өнөөгийн байдлаар бичил уурхайн улс төрийн, ёс суртахууны, оюун санааны, нийгмийн эрх зүйн орчин нь бүрдчихсэн бэлэн байгаа гэж үзэж болно.

Харин бичил уурхайн эдийн засгийн эрх зүйн орчин хараахан бүрдээгүй байна.

Эдийн засгийн эрх зүйн орчин болох бичил уурхайгаар олборлосон бүтээгдэхүүнийг хүлээн авах, үнэлэх, борлуулах талаар эрх зүйн зохицуулалт байхгүйгээс ченжийн гараар дамжин ямар нэг аргаар хил давдаг буруу тогтолцоо бий болсон нь нууц биш билээ. Иймд эл орчныг засан залруулж,

эдийн засгийн эрх зүйн орчныг зөв бүрдүүлэх томоохон ажил үлдэж байна.

Бичил уурхайн арга ажиллагааны зөвшөөрөгдөх доод, дээд болон нарийн хэм хэмжээсийг тогтоох технологийн заавар, техникийн баримт бичгүүд байхгүй, боловсруулагдаагүй байгаа. Иймд тэрхүү техник технологийн эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай байна. Ингэхгүйгээр бичил уурхай гэсэн бүрэн төгс ойлголт байхгүй болно.

Бичил уурхайд байгаль, экологийн зүгээс тавигдах хэм хэмжээний стандарт шаардлагуудыг бий болгосноор бичил уурхайн экологийн эрх зүйн орчин бүрдэнэ.

Сүүлд дурьдсан гол гурван эрх зүйн орчныг бүрдүүлж чадвал бичил уурхайн эрх зүйн орчныг бүрдлээ гэж үзэж болно. Үүний эцэст Монгол Улсад бичил уурхайн *хууль, эрх зүйн* орчин бүрэн бүрдэх бөгөөд цаашид сайжруулах, улам боловсронгуй болгох ажил л үлдэх болно.

ДӨРӨВ. БИЧИЛ УУРХАЙН ТАЛААР ТБУТ-ИЙН БАРИМТЛАЖ БҮЙ БАЙР СУУРЬ

ТБУТ 2011-2014 онд хэргжүүлэх төслийн III үе шатанд бичил уурхайг Монгол Улсын эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулахуйц албан ёсны дэд салбар болж цэгцрэхэд дэмжлэг үзүүлэх зорилготой.

Эл зорилгынхоо хүрээнд Монгол Улсын Эрдэс баялаг, эрчим хүчний яамтай хамтран дараах зорилтуудыг тавьж ажиллаж байна. Үүнд:

1. Бичил уурхайд чиглэсэн төрийн таатай бодлогыг дэмжин албан ёсны, хариуцлагатай бичил уурхайг төлөвшүүлэх тохиромжтой хууль, эрх зүй, зохицуулалтын орчныг сайжруулахад идэвхижүүлэгчээр ажиллах, бичил уурхайн талаар ил тод, бодлого болон эрх зүй, зохицуулалтын орчинг бүрдүүлэх, хэрэгжилтийг сайжруулах;
2. орон нутгийн бичил уурхайчдыг аюул осолгүй, байгаль орчны болон нийгмийн хариуцлагатай, эдийн засгийн хувьд үр ашигтай үйл ажиллагааг өөрсдийнхөө орон нутагт явуулах чадавхийг бий болгох, бичил уурхайчдыг тэрхүү зорилгод хүргэхийн тулд зохион байгуулалтад орох, үйл ажиллагаагаа албан ёсны болгоход нь дэмжлэг үзүүлж эрх мэдэлжүүлэх;

ТБУТ бичил уурхайн эрх зүйн орчныг бүрдүүлэх үйлсийн төлөө хамтрагч талуудын хамт нэлээд амжилтанд хүрсэн өнөөгийн нөхцөлд төслөөс баримтлаж буй гол байр суурийг тодорхойлбол:

1. Нэгэнт бичил уурхайн хууль зүйн орчин бүрдэж, түүгээр дамжаад нийгмийн эрх зүйн нийтлэг үйлчилгээтэй актууд бичил уурхайд ч нэгэн адил үйлчлэх бололцоотой болж байгаа учраас эдгээр хууль, эрх зүйн орчны олон талт нөхцлүүдийг хооронд нь сайтар уялдуулж, бичил уурхайд зөв зохистой ашиглах, хэрэглэх арга замуудыг тоймлон боловсруулахад идэвхитэй оролцох;
2. Бичил уурхайн холбогдолтой хууль тогтоомжийг бичил уурхайчид болон орон нутгийн холбогдох байгууллагын

- ажилтнуудад тайлбарлан таниулах, сурталчлах, сургалт зохион байгууулах, хэрэгжүүлэх ажилд дэмжлэг үзүүлж, идэвхижүүлэгчээр ажиллах;
3. ХАМО-дын үйл ажилагааг бичил уурхайн хэлбэрт шилжүүлэх, түүнд тохирсон арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэхэд нь Засгийн газарт бодит дэмжлэг, туслалцаа үзүүлэх;
 4. Хамтран ажиллаж буй аймаг, сумдад ТБУТ-ийн хэрэгжилтийн явц ямар байгаад дотоодын үнэлгээ хийж, тэргүүний сайн туршлагыг нийтэд таниулах, дэлгэрүүлэх;
 5. Бичил уурхайн загваруудыг бий болгоход чиглэсэн арга ажиллагааг идэвхитэй дэмжих;
 6. ХАМО-дын үйл ажилагааг бичил уурхай болгох үйл явцыг идэвхижүүлэгчдийг сургах, туршлага солилцуулах;
 7. Бичил уурхайн эдийн засгийн эрх зүйн орчныг бүрдүүлэхэд төрийн ба төрийн бус байгууллага, банк, санхүүгийн байгууллагатай хамтран ажиллах;
 8. Бичил уурхайн техник технологи, экологийн эрх зүйн орчныг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах;
 9. Бичил уурхайчдын санаачлагаар байгуулагдсан ТББ-тай бичил уурхайчдын нийтлэг эрх ашгийг хамгаалах, эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны нөхцлийг сайжруулах чиглэлээр хамтран ажиллах;
 10. Бичил уурхайн хууль, эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр хамтран ажиллагч талуудад туслалцаа, дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах;
 11. Монгол Улсын бичил уурхайн ололт амжилт, ажлын туршлагыг гадаад орнуудад сурталчлах, туршлага солилцоход нь туслалцаа үзүүлэх;
 12. Бичил уурхайн хөгжлийг хөхиүлэн дэмжсэнээр хөдөө орон нутагт ажлын байрыг бодитойгоор нэмэгдүүлэх;
 13. Хөдөөд ядуурлыг бууруулахын тулд холбогдох талуудын хүчин чармайлтыг уялдуулан зохицуулах.



ТАВ. БИЧИЛ УУРХАЙН ЦААШДЫН ЧИГ ХАНДЛАГА

Бичил уурхайн мөн чанар нь “Газрын тухай” болон “Ашигт малтмалын тухай” хуулиудаар зөвшөөрсөн талбайд зохион байгуулалттайгаар, зохих техник технологи хэрэглэн, бичил уурхайн эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны батлагдсан дүрэм, зааврыг мөрдөж, эдийн засгийн үр ашигтайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагааг эрхлэхийн зэрэгцээ байгаль, нийгмийн өмнө тодорхой үүрэг хүлээдэг байхад оршино.

Бичил уурхайн ирээдүйн хөгжлийн чиг хандлага ч үүнд чиглэгдэх ёстой. Үүний тулд дор дурьдсан чиглэлүүдийг төр, захиргааны болон дэмжин туслагч төрийн бус, олон улсын байгууллагууд, хууль хяналтын байгууллагууд, бичил уурхай эрхлэгчид, ард иргэд баримтлан, тэдгээрийн хэрэгжилтийн төлөө хүчээ нэгтгэн ажиллах нь эдийн засгийн дэд салбар болгож төлөвшүүлэхэд шийдвэрлэх нөлөө үзүүлнэ. Үүнд:

- ❖ Хувиараа ашигт малтмал олборлох үйл ажиллагаанаас бичил уурхайд шилжих шилжилтийн хугацааг тодорхойлж, арга хэмжээг төлөвлөх;
- ❖ Хууль зөрчигчдөд чанга шаардлагатай хандаж, хууль зөрчигч болон бичил уурхай эрхлэгчийг ялгаж зааглахад хууль хяналтын болон хүчний байгууллагын хүчийг ашиглах;
- ❖ Бичил уурхайгаар ашиглаж болох ашигт малтмалын жагсаалтыг гаргаж, Засгийн газраар батлуулах;
- ❖ Бичил уурхай ажиллуулах орд, илэрцийн жагсаалтыг орон нутгаар нь гаргаж, жил бүр баяжуулж байх;
- ❖ Бичил уурхайгаар ашиглах ашигт малтмалын төрөл, орд, илэрцийг уул геологийн нөхцлөөр нь ангилж, ангилал тус бүрт тохирсон технологийн заавар боловсруулж, түүний дагуу сургалт зохион байгуулахад мэргэжлийн сургууль, шинжлэх ухааны байгууллагуудын нөөц бололцоог ашиглах;
- ❖ Бичил уурхайн эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны байдалд хяналт тавих, зааварчлагаар хангах, тусламж үзүүлэх зориулалттай бичил уурхайн аврах хөдөлгөөнт багийг бүс нутгуудад байгуулах замаар улсын хэмжээний сүлжээг

- Уул уурхайн аврах албаны туслалцаатайгаар бий болгон хөгжүүлэх, төсөв хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх;
- ❖ Бичил уурхайд геологи, уул уурхайн мэргэжлийн туслалцаа үзүүлдэг системийг тогтоох;
 - ❖ Сум, дүүрэгт бичил уурхайн асуудал хариуцсан ажилтныг ажиллуулах бүтэц орон тоог Засгийн газраар батлуулах;
 - ❖ Бичил уурхайн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ боловсруулах журам, нөхөн сэргээлтийн стандартыг байгаль орчин, мэргэжлийн хяналт, мэргэжлийн байгууллагууд хамтран боловсруулж, хэрэгжүүлэх;
 - ❖ Бичил уурхайгаас олборлосон эрдэс баялгийн бүтээгдэхүүний эдийн засгийн эрх зүйн орчинг бүрдүүлэх санаачлага гаргаж, хэрэгжүүлэх;
 - ❖ Бичил уурхайгаас олборлосон бүтээгдэхүүнийг бүрэн боловсруулах, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх жижиг, дунд үйлдвэрийн үүсгэл санаачлагыг бүх шатанд дэмжих;
 - ❖ Бичил уурхайн үйл ажиллагаатай холбоотой шинжлэх ухааны судалгаа, холбогдох ном, товхимол, гарын авлагууд бэлтгэх, орчуулах, хэвлэх олшруулах ажлыг дэмжих;
 - ❖ Бичил уурхайн багаж, тоног төхөөрөмж үйлдвэрлэдэг үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийг үүсэж бий болоход нь дэмжлэг үзүүлэх;
 - ❖ Тэсэлгээчдийг сургаж бэлтгэх, бичил уурхайн тэсэлгээний ажлыг зохих зөвшөөрөл, журмын дагуу гүйцэтгэдэг болох, бичил уурхайд зориулан тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг зохих журмаар олгодог болох;
 - ❖ Бичил уурхайн ашиглалтын болон боловсруулах технологийн хаягдалд хяналт тавих системийг тогтоох, шаардлагатай лабораторийг бичил уурхай олонтой бүс нутагт байгуулахад томоохон лабораториудын анхаарлыг хандуулах;
 - ❖ Бичил уурхайгаар ашиглаж болох ашигт малтмал, ордын уул геологийн ангилал бүрийн онцлогт тохирсон бичил уурхайн загваруудыг эн түрүүнд бий болгож, бусдад нь үлгэр дууриалал үзүүлэх.


ЗУРГАА. ГАДААД ОРНУУДЫН БИЧИЛ УУРХАЙН ХӨГЖЛИЙН ТҮҮХ, ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Хүмүүн төрөлхтөн үндсэндээ чулуун зэвсгийн үеэс эхлэн эрдэс чулууг амьдрал ахуйдаа хэрэглэж эхэлсэн гэж болох юм. Хүрэл зэвсгийн үед нэлээд өндөр шатанд эрдэс баялгийг ашиглаж байсан гэдгийг хүмүүс түүхийн хичээлээсээ мэдэх байхаа. Эхлээд багаж, зэр зэвсэг, сав суулга мэтийн амьжиргааны хэрэгсэл байснаа эд агуурс, зүүлт, гоёл чимэглэл, урлал бүтээл, байшин барилгын гоёл, улмаар арилжаа, наймаа, хөрөнгө зөөрийн, цаашлаад үйлдвэрлэлийн зориулалтаар ашигласаар ирсэн байж таарна.

Энэ бүгд нь эхлээд газрын гадаргуу дээрхи ил байгааг нь ашиглаж байгаад цаашдаа газрын хэвлий рүү гүнзгийрэн орж гар уурхай, бичил уурхай, жижиг, дунд, том, аварга том уурхай болон хөгжсөн байх. Үүнийг бүхий л улс орнууд дамжсан нь тодорхой. Эдүүгэг хүртэл нэн урт удаан, хэдэн мянган жилийн хугацаанд уурхайн бүх хэлбэрээр олборлож байгаа ашигт малтмалуудаас хамгийн алдартай нь алт хэмээх үнэт металл байх юм. Хүн төрөлхтөн бараг бүх түүхэндээ алтыг гоёл чимэглэл, арилжааны хэрэгсэл, баян чинээлгийн хэмжүүр болгон ашиглаж иржээ.

Одоо дэлхийн хэмжээнд олборлож байгаа нийт алтны 10%, мөнгөний 10%, зэсийн 8%, цайрын 11%, хайлуур жоншны 90%, өнгөт чулууг 100%, элс хайрганы 30%-ийг гар болон бичил уурхайгаар олборлож байна.

Сүүлийн 10 жилд бичил уурхайгаар амьдралаа залгуулдаг иргэд даруй 7 саяаар нэмэгдэж эдүгээ дэлхийн 55 улсад 20 орчим сая хүн хувиараа ашигт малтмал байнга олборлож байгаагийн 30% нь эмэгтэйчүүд, 7.7% нь хүүхэд, тэд 100 сая орчим хүний амьжиргааг залгуулж байгаа гэсэн тооцоо байна.



Дэлхийн бичил уурхайчдын тархалт,
 нягтрал (1999 – 2002 оны байдлаар)

Дэлхийн зарим улс дахь хувиараа ашигт
 малтмал олборлогчдын тоо /мянган хүнээр/

Боливи	72	Мозамбик	60
Бразили	10	Өмнөд Африк	10
Буркино-Фасо	100-200	Папуа шинэ Гвине	50-60
Гана	200	Перу	30
Замби	30	Танзани	550
Зимбаби	350	Хятад	3000-15000
Индонези	109	Филиппин	185
Малави	40	Эквадор	92
Мали	200	Энэтхэг	500

ДОЛОО. БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛЖ БУЙ ЗАРИМ УЛСЫН ТУРШЛАГА

Дэлхийн улс орнууд ХАМО-дын болон бичил уурхайн үйл ажиллагааг янз бүрийн аргаар зохицуулахыг оролдож байгаа бөгөөд зарим нь нэлээд амжилтанд хүрсэн байх юм. Зарим нэг орнуудын туршлагаас сийрүүлбэл:

Боливи: ХАМО болон бичил уурхайн тодорхойлолт байхгүй. Уул уурхайн ерөнхий хууль, Хоршооллын хууль, Байгаль орчны хууль зэрэг хууль зүйн актуудаар зохицуулдаг. Бичил уурхайчид нь хоршооллын зохион байгуулалттай ажилладаг. Хоршоололд лицензи олгоно. Лицензийн талбай нь 2500 га-аас хэтэрдэггүй. Лицензийн төлбөр төлдөг. Комибол хэмээх уул уурхайн улсын компани ихэнхи лицензийг эзэмшдэг. Түүнээсээ хоршоололд олгодог байна.

Гана: Бичил уурхайн хэлбэрээр ажилладаг. Бичил уурхайг эзэмшиж буй талбайн хэмжээгээр нь тодорхойлдог. 5 жилийн хугацаагаар лицензи олгоно. Лицензийн талбай нь тодорхой журмын дагуу зохицуулагддаг. Хяналт шалгалтыг маш сайн тавьдаг. Энэ нь лицензийг сунгах эсэх асуудлыг шийдвэрлэхэд хялбар байдаг. Зөвшөөрлийн бичигтэйгээр тэсрэх материалыг хэрэглэдэг. Лицензийн төлбөрийг дээрхи журмаар зохицуулдаг байна.

Лаос: ХАМО-чид нь бичил уурхайдаа хамаардаг. Гэхдээ зөвхөн гар багажаар ажиллахыг зөвшөөрдөг. Концессийн гэрээгээр ажиллуулдаг. Олборлолт хийхэд зориулсан багаж төхөөрөмжөө хуульд заасны дагуу бэлтгэхийг шаарддаг. Олборлолт хийхэд зайлшгүй шаардлагатай цахилгаан эрчим хүч, ус болон бусад зүйлийг хэрэглэх гэрээг Засгийн газартай хийж болдог. Гэрээ нь 30 жилийн хугацаатай байна. 10 жилээр 2 удаа сунгаж болно. Уурхайн ашиглалтын лицензи авбал Засгийн газар нь хөрөнгө оруулж болдог. Лицензи эзэмшигч уурхайн ашиглалтын техник технологийн талаар Засгийн газраасаа зөвлөмж авах эрхтэй. Хуульд заасны дагуу татвар төлдөг.

Мексик: Бичил уурхайн жилийн бохир орлого нь жилд ажиллагсаддаа олгосон цалингийн хамгийн бага хэмжээнээс

5000 дахин, дунд хэмжээний уурхай нь 20000 дахин их байх шаардлагатай. Бичил уурхай сард 300 тн, дунд зэргийн уурхай сард 12000 тн ашигт малтмал олборлодог байна. Концессийн гэрээгээр, эсвэл уралдаант шалгаруулалтаар ажиллуулдаг. Уурхайн мөргөцгийн урт 100 м, түүнээс илүү байна. Гэрээний хугацаа 50 жил байна. Хуулийн дагуу татвар төлнө.

Папуа Шинэ Гвине: Ямар ч машин техник хэрэглэхгүйгээр зөвхөн гар багаж хэрэгслээр ажиллана. Уурхайн эдэлбэр олгож журмаар зохицуулна. Үндсэн ордод 60 хавтгай дөрвөлжин км-ээс, шороон ордод 5 га-аас ихгүй тэгш өнцөгт, эсвэл олон өнцөгт хэлбэрийн талбай олгоно. Үндсэн ордод 20 жилээр олгож, 10-аас илүүгүй жилээр сунгана. Шороон ордод 5 жилээр олгож 5-аас ихгүй жилээр сунгана. Том уурхайнуудыг хаагдсаны дараа ХАМО-дыг ажиллуулах бодлого баримталдаг.

Перу: Хоногт 350 тн хүдэр эсвэл 3000 шоо метр элс, шороо олборлох хүчин чадалтай уурхайг бичил уурхай гэнэ. Бичил уурхай 2000 га хүртэл газар эзэмшиж болно. ХАМО-чид хоногт 25 тн хүдэр олборлох бөгөөд 1000 хүртэл га талбай олгоно. 1991 онд Уул уурхайн ерөнхий хууль, 2001 онд бичил уурхай ба ХАМО-дын хууль батлагдсан. Хоршооны журмаар ажилладаг. Металл олборлогчид 1 га газрын төлбөрт жилд 50 доллартай тэнцэх үндэсний мөнгө, металл бус ашигт малтмал олборлогчид 25 доллартай тэнцэх үндэсний мөнгө 1 га тутамд төлдөг. Том уурхай үүнээс 2 дахин ихийг төлдөг байна. Улсаас тогтоосон хэмжээгээр татвар төлдөг. Газар нутгийн байршил, хоршооны гишүүдийнхээ тооноос хамаараад нийгмийн асуудлаа янз бүрээр шийдвэрлэдэг. 500- 1000 гишүүдтэй зарим хоршоо сургууль, эмнэлгийн асуудлаа өөрсдөө шийдвэрлэсэн тохиолдол ч байна.

Тайланд: Бичил уурхайчид хуурай газраас болон усан доороос хувиараа ашигт малтмал олборлодог. Ашигт малтмалын төрөл, боловсруулах аргаас нь хамаараад талбайн хэмжээ янз бүр байна. Яамнаас гаргасан журмаар зохицуулагдана. Хүдэр угаагчид гэж байдаг. Мөн янз бүрийн талбайд ажиллана. Яамны тушаалаар үйл ажиллагаа нь зохицуулагдана. Тус бүрдээ лицензитэй. Түүнийг нь орон нутгийн уул уурхайн үйлдвэрлэл хариуцсан эрх бүхий байгууллага олгоно. Тогтоосон хэмжээгээр татвар, хураамж төлдөг байна.

Филиппин: Тэсэлгээ хэрэглэхгүй, хүнд машин механизм

ашиглахгүйгээр гар багажаар голдуу ажилладаг. Лицензи эзэмшигчдийн талбайд гурвалсан гэрээний журмаар ажилладаг. Хувийн газар дээр газрын эзэнтэй гэрээ байгуулан олборлосон бүтээгдэхүүнээсээ тодорхой хувь өгөх тохиролцоотой ажилладаг. Уртраг, өргөрөгийн 15 секундэд харгалзах талбай олгоно. Энэ нь 20 га орчим байдаг. 2 жилээр олгож, 2 жилээр сунгана. Олборлосон 300 граммаас дээш хэмжээтэй алтыг Төв Банк нь худалдан авдаг. Хот, дүүргийн Уул уурхайн зохицуулах хороод үйл ажиллагааг нь удирдан зохион байгуулдаг. Сайн дурын үндсэн дээр нөхөрлөл байгуулах маягаар ажилладаг. Хот, дүүргийн Уул уурхайн зохицуулах хороонд бичил уурхай, том уурхайгаас тус бүр 1 төлөөлөгч ордог байна.

Эквадор: ХАМО-ч хувь хүн, гэр бүл, хоршооллын хэлбэрээр ажилладаг. Хоногт 300 тн хүдэр буюу 800 шоо метр шороо олборлодог уурхайг бичил уурхай гэж нэрлэсэн байдаг. Концессийн болон энгийн гэрээгээр ажиллуулдаг. Үйлдвэрлэлээ явуулахад шаардлагатай байшин барилга барьж, осол, аваргүй ажиллах нөхцлийг бүрдүүлэх шаардлагатай. Үйлдвэрлэлийн болон бусад зориулалтаар ус ашиглаж болно. 5000 га-аас илүүгүй газрыг ХАМО-дод 10 жил, бичил уурхайд 25 хүртэлх жилийн хугацаагаар олгоно. Ашиглалтын жилээсээ хамааруулан талбайн төлбөрт жилд 1га тутамд 2, 4, 10 доллар төлдөг.

Зарим гадаад оронд ХАМО-чид болон бичил уурхайн хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэхдээ ямар арга хэрэглэж байгааг анхааран үзвэл ерөнхийд нь 5 аргад хувааж болохоор байна. Үүнд:

1. Бичил уурхай, ХАМО-дын үйл ажиллагааг тусгай гэрээгээр зохицуулдаг улс: **Перу**
2. Уул уурхайн ерөнхий хууль болон байгаль орчны хууль, Хоршооллын тухай хуулиар зохицуулдаг улс: **Боливи**
3. Журмаар зохицуулдаг улс: **Гана, Тайланд**
4. Тухайн үед нь тохиролцож шийдвэрлэдэг улс: **Филиппин**
5. Концессын гэрээгээр зохицуулдаг улс: **Лаос, Мексик, Папуа Шинэ Гиней, Эквадор.**

Эдгээр улс орны бичил уурхайн эрх зүйн орчныг бүрдүүлж

байгаа арга барил, туршлага улс орон бүрийн өөр өөрийн онцлог байдалд зохицсон байх нь тодорхой бөгөөд тухайн орны төр, засгийн идэвхи, санаачлагаас хамаарах нь мөн тодорхой юм. Өнөөгийн байдлаар бичил уурхайг жинхэнэ ёсоор хөгжүүлээд гялалзсан амжилтанд хүрсэн улс төдийлөн байхгүй байна.

Манай улс энэ асуудлаар багагүй амжилттай яваа гэж хэлж болно. Гэхдээ гадаад орнуудын туршлагаас харахад дийлэнх орнууд бичил уурхайчдад олгох газар, талбайг зоригтойгоор ахиухан шиг овоо хэдэн жил тогтвортой үйл ажиллагаа явуулахуйц, амьдралд нь хүрэлцэхүйц хэмжээгээр, удаан хугацаагаар олгодог байна.